

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-43

1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	4-42
2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	42-43

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 05 дугаар сарын 05-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 31 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар
2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхээсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатангуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Ж.Батсуурь, М.Оюунчимэг, Т.Доржханд, Д.Сарангэрэл, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн 11 цаг 06 минутаас 11 цаг 17 минутад хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Сарангэрэл, Г.Ганболд, Ц.Мөнхцэцэг, Ж.Батсуурь, Т.Доржханд нар үг хэлэв.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Н.Энхболд: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 3
Бүгд: 15
80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор Н.Ууганбаатар, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн референт Б.Галсанбат, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Н.Энхболд: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 30 минут үргэлжилж, 19 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон
“Жанжин Д.Сүхбаатар” танхим
09 цаг 31 минут.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023
ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ 05 ДУГААР
САРЫН 05-НЫ ӨДӨР /БААСАН
ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Ирц бүрдсэн байна. Ингээд Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 05 сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл. Монгол Улсын Засгийн газар өргөн мэдүүлсэн. Нэг дэх хэлэлцүүлэг явагдана.

Хоёрт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл. Мөн Засгийн газраас 05 сарыг 03-ны өдөр өргөн мэдүүлсэн энэ 2 асуудлыг хэлэлцэх эсэхийг нь шийднэ.

Саналтай гишүүн байна уу? Байхгүй. Асуудалдаа оръё.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл нэг дэх хэлэлцүүлгийг явуулна.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл /Засгийн газар 2023.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Засгийн газраас 05 сарыг 03-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Х.Нямбаатар сайд танилцуулна.

Би ажлын хэсгийг хэлээдэхье. Өнөөдрийн хуралдаанд Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар ирсэн байна. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Хэрэг эрхлэх газрын даргын зөвлөх Ү.Амарбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Дондогмаа, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хуулийн багийн ахлах зөвлөх Ч.Ариунхур, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн танхимын дэд профессор Н.Ууганбаатар.

Энэ хүмүүсийг дуудаарай. Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын танхимын профессор Д.Бумдарь.

Ийм хүмүүс ажлын хэсэгт орсон байна.

Х.Нямбаатар сайдыг төсөл санаачлагчийн илтгэлээ тавихыг урьж байна.

Х.Нямбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурал 2022 оны 54 дүгээр тогтоолоороо Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 01, 02 дугаар тогтоол гарсантай холбогдуулан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн харилцан хяналт, тэнцлийг хангах хүрээнд төрийн эрх барих дээд байгууллагад ард түмнийг төлөөлөх Улсын Их Хурлын гишүүдийн тоог шинэчлэн тодорхойлох, Улсын Их Хурлын сонгуулийн дэвшилтэт тогтолцооны зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулиар

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

баталгаажуулах асуудлыг судлан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлаар ард иргэдийн оролцоо, ил тод байдлыг хангах зорилгоор олон нийтийн саналыг судлах сэдвийн хүрээг тодорхойлж сонгуулийн холимог тогтолцоог нэвтрүүлэх, сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмэгдүүлэх асуудлыг тусгасан.

Мөн 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр улс төрийн 21 нам Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг гаргаж Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хамрах хүрээнд сонгуулийн холимог систем бүхий олон намын оролцоотой зөвшилцлийн ардчилалд ишлжих, сонгогчдыг төлөөлөх мандатын тоог нэмж, Улсын Их Хурлын нэг гишүүний нөлөөллийн эрх мэдлийг багасгахыг дэмжиж тунхаг бичиг гаргасан.

Улсын Их Хурлаас 2023 оны 1, 2 дугаар сард зохион байгуулсан “Зөвлөлдөж шийдье” Улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгын зөвлөмжөөр иргэдийг төлөөлөх парламентын чадавхыг нэмэгдүүлж, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, Улсын Их Хурлын сонгуулийг явуулахдаа олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоог хослуулах нь зүйтэй гэсэн саналуудыг дэмжсэн дүн гарсан.

Эдгээр хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, улс төрийн намуудын оролцоог хангах хүрээнд төслийг танилцуулах, хэлэлцүүлэх, саналыг авах ажлыг зохион байгуулсан.

Тухайлбал, 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаар улс төрийн 25 намын удирдлага, иргэний нийгмийн болон судлаачдын төлөөлөл оролцоотой хэлэлцүүлэгт Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг дэлгэрэнгүй танилцуулж хэлэлцүүлээ.

Мөн төслийг улс төрийн бүх намд албан бичгээр хүргүүлж саналыг авлаа.

Мөн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл, үндэслэл, тайлбарыг Засгийн газрын болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим хуудас, түүнчлэн хуулийн төслийн хэлэлцүүлгийн D-Parliament цахим хуудаст тус тус байршуулж, төслийн талаар иргэд, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, эрдэмтэн, судлаачдын төлөөллөөс бүрдсэн багууд төслийг иргэдэд танилцуулан хэлэлцүүлж, санал авах хэлэлцүүлгийг 21 аймагт зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт нийт 6 мянга орчим иргэд биечлэн оролцож, 5 мянга гаруй саналыг саналын хуудсаар давхардсан тоогоор 33 мянга 900 гаруй санал өгсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 10.1.4-д Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж санал авсан байх гэж заасны

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн болно.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төсөлд иргэдийг төлөөлөх парламентын чадамжийг сайжруулах хүрээнд Улсын Их Хурлын гишүүдийн тоог 152 болгон хүн амын тоотой уялдуулан нэмэгдүүлэх мажоритар болон пропорциональ аргын давуу талуудыг тусгасан сонгуулийн тогтолцоотой болох, Улсын Их Хурлын нийт гишүүний 50 хувийг мажоритар, 50 хувийг пропорциональ аргаар сонгох зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулахаар тусгалаа.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Нямбаатар сайдад баярлалаа.

Одоо гишүүд асуулт асууна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж байхад Байнгын хороонд оролцож байгаа гишүүд асуух хугацаа 8 хүртэл минут. Нэг удаа 2 минутаар сунгаж болно.

Асуултад хариулах хугацаа 8-аас илүүгүй хугацаанд хариулна. Нэг удаа нэмж тайлбар хэлж болно. Хариулахдаа. Гишүүд дараа нь үг хэлнэ. Үг хэлэх хугацаа 10 минутаас хэтрэхгүй ийм зохицуулалттай.

Ингээд хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуух гишүүд нэрсээ өгье. Б.Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Засгийн газраас оруулж ирж байгаа төслийг зарчмын хувьд дэмжиж байна.

Миний хувьд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үргэлжлэл гэж энэ удаагийн төслийг харж байна.

2019 онд эрдэмтэн, судлаачид тухайн үед улс төрийн намуудын тодорхой байр суурь бүгд л парламентыг төлөөлөх чадварыг сайжруулах, гүйцэтгэх ба хууль тогтоох засаглалын харилцан хяналт, тэнцлийг сайжруулах үүднээс гишүүдийн тоо нэмэх нь зүйтэй гэж орж ирсэн юм.

Гэтэл тухайн үеийн тодорхой улс төрийн хүчнүүдийн, институцийн хоорондын үл ойлголцлоос болоод тоо нэмэх асуудал уначихсан юм.

Уг нь 2019 онд тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бид бүтнээр нь хийж чадсан бол одоо ингээд 3 жил, 4 жилийн дараа дахиж ярих ёсгүй байсан юм.

Тийм учраас бид нэгэнт эхлүүлсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн шинэчлэлийг одоо дуусгах нь зүйтэй. Тийм учраас энэ дээр тодорхой байр сууриудаа дэмжиж байна.

Ер нь Монгол Улсын хувьд газар нутгийн, тэгээд геополитикийн, газар зүйн нэлээд олон онцлог чухал факторуудаас харахад Монгол Улсын парламентын ардчилал үндэсний аюулгүй байдлыг дэмжихэд яах аргагүй тогтолцооны томоохон реформ хэрэгтэй байгаа.

Энэ дотроо хүн амын тоогоо тэгш төлөөлсөн, нийгмийн бүлгүүдийн бүтцийг төлөөлсөн, дээр нь хөрш орнуудын геополитик, улс төрийн нөхцөлүүдийг харгалзсан ийм шинэчлэлийг хийхийн тулд бид тооны асуудлыг хөндөх нь зүйтэй. Тэгээд бид өнгөрсөн зун тойрог дээрээ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ажиллаж гишүүд маань иргэдийнхээ саналуудыг авч байсан.

Ер нь олонх нь парламентын ажлаа бэхжүүлэх тал дээр энэ тооны асуудлыг дэмжиж байгаа. Тэгэхдээ яг иргэдийн дунд тодорхой хэд хэдэн ийм эргэлзээтэй асуудлууд байгаа юм. 76 гишүүнийг 150-иар болгоход яг онолын болон бусад үндэслэл юу байна? Энэ дээр судалгаанууд хэр хийгдсэн гэдэг дээр хүмүүс тодорхой асууж, бидэн лүү тодорхой асуултууд ирж байна.

Энэ дээр манай ажлын хэсэг болон судлаачид, эдийн засгийн, статистикийн бусад харьцуулсан судалгааны үр дүн дээр чухал үндэслэлүүдийг тодорхой хэлж өгөх хэрэгтэй байгаа.

1 дүгээр асуулт, тоо нэмэх үндэслэлүүдийг дэмжсэн эдийн засаг, улс төрийн гол байр сууриудыг ажлын хэсгээс асууя.

2 дугаарт нь, ер нь парламентын засаглалд хувь хүний хүчин зүйлийн нөлөө гэдэг юм уу, хувь улс төрчийн. Олны дунд ярьдгаар популистуудын нөлөө бага байх ёстой. Ер нь ардчилсан засаглал хувь хүн хэн байхаас үл хамаараад тогтолцооныхоо найдвартай байдал, тогтолцооны хяналт, тэнцвэрийн байдалд илүү найдах ёстой юм.

Гэтэл бид нарын хэрэглэж ирсэн 30 жилийн мажоритар систем улс төр дэх хувь хүний нөлөөг асар өндөр болгосон, тойргоор хуваагдсан. Тэр дотроо жижиг тойргууд дахь тодорхой улс төрчийн нөлөө асар хүчтэй байж ирсэн.

Энэ маань эргээгээд улсын төсөв болон бодлого дээр стратегийн хүчин зүйл бүхий томоохон шийдвэр гаргахад байнга сөргөөр нөлөөлж ирсэн байдаг.

Тийм учраас манай судлаачдын, Үндсэн хуулийн эрх зүйчдийн, улс төрийн шинжлэх ухааны докторуудын зөвлөж

ирж байгаа гол байр суурь ерөөсөө тогтолцоогоо шинэчлэх, бодлогын улс төр хийх боломжийг гаргаж өгөх. Үүний тулд бодлогын намуудыг төлөвшүүлэх, парламент дахь бодлогын улс төрийн орон зайг илүү нэмэх нь зүйтэй гэж үздэг. Энэ утгаараа энэ холимог системийг дэмжиж байна.

Ер нь холимог систем гэдэг намын бодлогын улс төр, ардчилсан нийгэм дэх парламентын шийдвэр гаргах гол институт болж байгаа намыг бэхжүүлэхэд чухал үүрэг нөлөөтэй байгаа.

Намын бодлого, намын улс төр гэдэг энэ шийдвэр гаргах гол механизм байдаг. Түүнээс биш хэн нэгэн хувь улс төрчийн тоглолт, эсвэл тухайн сонгуулийн үед санамсаргүй байдлаар гарч ирсэн тохиолдлын маягийн улс төрчдийн нөлөөг хязгаарлах боломжтой.

Тийм учраас 2 дахь үндэслэл буюу энэ холимог тогтолцоо гэдэг Монгол Улсын ирээдүй дэх бодлогын улс төр, стратегийн улс төрийг бэхжүүлэх асар том зүйл гэдгээр дэмжиж байна. Энэ дээр мөн ажлын хэсгээс нэмэлт үндэслэлүүд байна уу?

Ер нь өнгөрсөн жилүүд дэх энэ мажоритар системийн улс орны хөгжилд үзүүлсэн сөрөг нөлөө, төсвийн бодлогын хуваарилалт, хөгжлийн бодлогуудад сөргөөр нөлөөлж ирсэн сөрөг нөлөөг ажлын хэсгээс маань дахин дэлгэрэнгүй тайлбарлаж өгөх хэрэгтэй байна.

Ер нь манай олон нийтийн дунд мажоритар тогтолцоог халах, тойрог угаадаг, олон жил тойрог угааж сонгогдсон мажоритар системийн сул талыг арилгах гэдэг дээр олон нийт маань дэмжиж байгаа.

Энэ дээр нэмэлт мэдээллүүд хэрэгтэй байна. Ийм хоёр асуултыг ажлын хэсгээс тодруулж асууя. Баярлалаа.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Н.Энхболд: Нямбаатар сайдын цаг өгье. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулья. Микрофоныг нь.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Мөнхцэцэг гишүүний бүх хэлж байгаа зүйлтэй санал нэг байгаа юм.

1990 онд Монгол Улсын эдийн засаг энэ 33 жилийн хугацаанд бараг 300 дахин өссөн хэдий ч ядуурлын хувь хэмжээ 5, 6-хан хувиар өөрчлөгдсөн.

Өөрөөр хэлбэл бидний мажоритар тогтолцооны хамгийн алдаатай хэсэг нь энэ өнгөрсөн 33 жилийн эдийн засгийн суурь хэдэн үзүүлэлтээр л тодорхойлогдоно.

Монгол Улсын эдийн засаг хэдийгээр өсөж байгаа ч гэсэн 76 тойрогт хөрөнгө оруулалт нэрийн доор улсын төсвийг жигд тэгш хуваарилдгаас шалтгаалж томоохон макро эдийн засагт чухал нөлөө үзүүлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийг бид энэ 33 жилийн хугацаанд эргүүлж чадаагүй.

1984, 1985 оны үед хамгийн сүүлчийн цахилгаан станц ашиглалтад орсон. Үүнээс хойш энэ 40 гаран жилийн хугацаанд бид шинэ нэг ч цахилгаан станц барьж байгуулаагүй.

Бид импортоор нийт эрчим хүчнийхээ 25-аас 30 орчим хувийг жил болгон худалдаж авч байгаа. Эдийн засгийн өсөлт өндөртэй орнуудад GDP-гийнхээ өсөлттэй уялдаж эрчим хүч, энергийнхээ үйлдвэрлэлийг жил болгон урьдчилж төлөвлөж үйлдвэрлэж явдаг.

Тэгэхээр бид энэ тогтолцоо буюу мажоритар тогтолцооны 30 жилийн хугацаанд явсан хамгийн гол бидэнд ил харагдаж байгаа эмгэгүүдийг товчхондоо хэлж болох юм.

1991 онд тухайн үеийн Улсын Бага Хурал дахь Үндэсний дэвшлийн намаас эмхэтгэж хэвлүүлсэн Улсын Их Хурлын

гишүүдийн тоо хэд байх нь зүйтэй юм бэ гэдэг ийм судалгааны материалыг миний бие Улсын Их Хурлын номын сангаас олж аваад нийт гишүүдийн тоогоор хэвлүүлж Та бүгдийн туслахуудад хүргүүлсэн ийм судалгааны материалыг Та бүгдийг үзсэн байх гэж бодож байна.

Тэр үед одоогийн 76 гэдэг тоог гаргаж ирэхийн тулд 1-ээс 2 сая хүн амтай парламент болон зөвлөх парламентуудын дундаж жишигийг гаргаж ирээд тухайн үед 2.1 сая хүн амтай байсан Монгол Улсад 23 мянган хүнийг нэг Их Хурлын гишүүн төлөөлье гэдэг ийм дундаж статистик тоо гаргаж ирж өнөөдрийн 76 гэдэг гишүүдийн тоо гарсан байгаа.

Энэ хооронд Монгол Улсын хүн ам 3.4 сая орчим болтлоо өссөн. Өнөөдөр ойролцоогоор Монгол Улсын нэг Их Хурлын гишүүн 45 мянга орчим иргэдийг төлөөлж байгаа. Иргэдийг.

Улаанбаатар хотын нягтаршил ихтэй, хүн ам ихтэй дүүргүүдэд нэг Их Хурлын гишүүн 50 мянгаас илүү, зарим тохиолдолд 70 мянга орчим сонгогчийг төлөөлж байгаа ийм статистик гарч ирсэн байгаа. Тэгээд тооны хувьд 152, 76, 76 гэдгийг гаргаж ирсэн талаар манай ажлын хэсэг, эрдэмтэн, судлаачид тэр математик аргачлалын талаар нэмж хэлэх байх гэж бодож байна.

Тэгэхээр Их Хурлын гишүүдийн нэг гишүүнд ногдох хувийн жинг бууруулья гэдэг энэ зарчим 1 дүгээрт, сүүлийн бараг 10 гаруй жил Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд удаа дараагийн нэмэлт, өөрчлөлтөөр өргөн барьж байсан болон өргөн барихаар төлөвлөж, хэлэлцүүлгүүд зохион байгуулж байсан ийм зүйлүүд байдаг юм билээ.

Хамгийн их хүчтэй яригдаж байсан нь 2015 онд Улсын Их Хурлын гишүүн Батбаяр тэргүүтэй гишүүд Улсын Их Хурлын гишүүдийн тоог 99 болгоё гэдэг асуудал яригдсан.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

2019 оны нэмэлт, өөрчлөлтийн үргэлжлэл гэдэгтэй тантай 100 хувь санал нэг байгаа. Тухайн үед улс төрийн нам, эвслүүд, төрийн тэргүүний институцүүдийн зөвшилцөл үндсэндээ хийгдэж дуусаад, Улсын Их Хурлын гишүүдийн тоог 108 холимог тогтолцоотой болгоё гэдэг зөвшилцөл бараг дуусдагийн даваан дээр манай намын бүлгийн нэр бүхий гишүүд энэ зөвшилцлийг үндсэндээ зогсоосон. Үүнээс шалтгаалаад 2019 оны нэмэлт, өөрчлөлтийн төсөл гүйцэд хийгдэж чадаагүйгээс шалтгаалж бид өнөөдрийн энэ асуудлыг хэлэлцэхэд хүрч байгаа.

Зарим Их Хурлын гишүүд нэгэнт тооны асуудал ярьж байгаа бол, тогтолцооны асуудлыг ярьж байгаа бол иргэний үндсэн эрхтэй холбоотой асуудал, шүүх эрх мэдэлтэй холбоотой асуудал, магадгүй засаглал хуваахтай холбоотой асуудлуудыг нэг мөр хийвэл яасан юм бэ гэдэг талаар улс төрийн нам, эвсэл, судлаачдын зүгээс саналуудыг ирүүлсэн.

Энэ дээр манай намын удирдлагуудын түвшинд болон энэ ажлын хэсгийн түвшинд ярилцаад ямар шийдэлд хүрсэн бэ гэхээр нэг нам дийлэнх олонхыг бүрдүүлж байгаа энэ цаг үед Үндсэн хуулийн томоохон өөрчлөлтийг хийх нь бас тийм оновчтой биш юм.

Өөрөөр хэлбэл манай Үндсэн хуульд засаглал хуваах асуудлаа хүртэл бүрэн шийдэж чадаагүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ удаа Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 01, 02 дугаар тогтоолд үндэслэж гарч ирсэн Улсын Их Хурлынхаа 54 дүгээр тогтоолын дагуу Засгийн газар төслөө боловсруулж тоо тогтолцооныхоо л асуудлыг шийдье.

Магадгүй 2024 онд шинээр байгуулагдах шинэ парламент буюу олон намын төлөөлөл, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл бүхий парламент цаашид нийгмийн зөвшилцөл, нийгмийн гэрээгээ хэрхэн өөрчлөх эсэхээ шийдэх нь илүү

зохимжтой юм гэдэг байр сууриас өнөөдрийн төслийг боловсруулж оруулж ирсэн гэдгийг хэлье. Баярлалаа.

Н.Энхболд: Ажлын хэсгээс нэмэх зүйл байна уу? Дэд профессор Ууганбаатар. 6 номерын микрофон. Тооны үндэслэл.

Н.Ууганбаатар: Бүгдээрээ сайн байна уу. Тэгээд энэ 152 гэдэг тооны үндэслэлийг асууж байх шиг байна. Статистикийн судалгаа хэр зэрэг хийгдсэн бэ гэж байна. Зүгээр яах вэ, 76-г 2-оор үржээд 152 гарчаж гэж нэг ойлголт явагдаж байгаа.

Тэгээд нөгөө параллелийн 50, 50-тайгаа их сайхан нийцээд байх шиг байна гээд ард түмний түвшинд иймэрхүү маягаар ойлгогдож байгаа. Яг 152 гэдэг тоог сонгодог загварыг нь ашиглаж гаргаж ирсэн. Тэр загвар дээр юу харуулсан байдаг вэ гэхээр үнэхээр Улсын Их Хурлын гишүүдийн тоо хүн амын тоотойгоо аягүй сайн хамааралтай юм байна гэдгийг нь харуулсан байдаг. Ингэхээр хүмүүс гайхаад байх шиг байгаа юм. Зөвхөн хүн амын тоог нь тооцож үзлээ. Өөр юмыг нь тооцож үзэхгүй байна гээд.

Шинжлэх ухаанд ямар зарчим үйлчилдэг вэ гэхээр байгаа моделиуд дотроос бид хамгийн хялбарыг нь сонгодог. Тайлбарлаж болох юмнуудыг. Нэг юмыг олон янзаар тайлбарлаж болох байх. Мэдээж та нар бодоод үзэх юм бол бид нарын 10 жилд үздэг физикийн моделиуд бодоод үзэхээр дандаа нэг тэгшитгэлтэй амархан байдаг. Тэрийг мэдээж илүү төвөгтэй тэгшитгэл рүү орлуулж болно. Тэгэхийг шинжлэх ухаан зөв гэж үздэггүй. Байж болох хамгийн хялбар. Зөв тайлбарлаж байгаа хамгийн хялбар моделийг нь сонгодог. Тэгээд энэ зарчмын дагуу явахаар хүн амын тоо яалт ч үгүй хамгийн хялбар бөгөөд зөв тайлбарлаж байгаа ийм модель болж таарч байгаа юм.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Цаад талынх нь хамаарал нь юу байх вэ гэхээр хүн амын тоо болон парламентын гишүүдийн тооны аль алиныг нь логарифмыг нь авсны дараа хоорондоо шугаман хамааралтай болчихдог. Логарифм аваад шугаман хамааралтай болчихдог ийм хамаарлыг бид зэргийн хууль гэж шинжлэх ухаанд нэрлэдэг. Power Law. Зэргийн хууль. Нийгэм, эдийн засаг, цаг уур их олон газар энэ хүчинтэй байдаг.

Тэгээд үүний нэг хэлбэр байна л гэсэн үг. Тэгээд энэ зэргийн хуулийг аваад үзэхээр 1980-аад оны үед хийсэн тэр анхных нь судалгааг авч үзээд тэр дээр моделийг нь тавиад тооцоод үзэхээр 150 гэдэг тоо гарч ирж байгаа юм. Яг үнэндээ.

Одоо магадгүй ардчиллын хувьд нэлээн ахицтай яваа хамгийн топ явж байгаа. Тэгээд хүн ам цөөтэй улсууд дээр зөвхөн тэр улсуудыг салгаж аваад тооцоо хийгээд үзэхээр 162 гэдэг тоо гарч байгаа. Скандинавын орнууд дээр. Хүн ам цөөтэй буюу 200, 300 мянгаас дээш 12 саяын хооронд байгаа, тэгээд ажиллагаатай ардчилал гэдэг ангилалд ордог 24 орон дээр дахиад саяын тооцоог хийгээд үзэхээр 137 гэдэг тоо гарч байгаа юм.

Тэгээд үндсэндээ ер нь 137, 150, 162 гэсэн ийм 3 өөр тоо бол зэргийн хуулиас гарч ирж байгаа бөгөөд авч байгаа ерөнхий simple-аасаа хамаараад, түвшинээсээ хамаараад өөр өөр гарч байна гэсэн үг.

Дэлхийн дунджаар явъя гэвэл 150, ажиллагаатай ардчилалтай орнуудын түвшинээр явъя гэвэл 137, Скандинавын орнуудын түвшинээр явъя гэвэл 162. Тэр ажиллагаатай ардчилал бол 30-аад орон байгаа. Түүний 24 орчим нь ерөнхийдөө жижигхэн улсууд байдаг.

Эндээс дахиад ямар дүгнэлт хийж болж байгаа вэ гэхээр орчин үеийн нийгэмд чинь уг нь аваад явчихаар 2

үндсэн динамик байгаа шүү дээ. Нэг нь капитализм. Нөгөөдөх нь ардчилал. Тэгээд энэ хоёрыг л их зөв урлаж чадах юм бол энэ улс орон орчин үеийн улс болж хөгжих ийм боломжтой гэж харагдаж байгаа.

Тэгээд яах вэ, капитализм нь нэлээн хэцүү байх шиг байгаа юм. Магадгүй манайд 90 хувь нь гадаадаас хамааралтай шахуу ийм капитализмтай болчихсон. Ардчилал эсрэгээрээ бид 90 хувь нь бид нарын дотоодоос хамааралтай болов уу гэж. Тэгээд эхний удаад энэ ардчилалаа бэхжүүлэх тал дээр ийм ажиллагаа хийгдэж байгаа юм болов уу гэж би хувьдаа ингэж ойлгосон.

Дараа нь нэг дурдах ёстой зүйл бол одоогийн систем нөгөө гээгдсэн санал гэдэг юм нэлээн өндөр гараад байдаг. Ер нь ойролцоогоор 27 хувьтай. 2020 оны дата дээр үзэх юм бол Монгол Улсын сонгуулийн системээс үүсэж байгаа гээгдсэн санал 27 хувьтай гэж гарч байгаа юм. Дэлхийн дундаж нь 8 хувьтай харагдаж байгаа юм. Тэгэхээр бид энэ дээр нэлээн хол зөрж байна гэсэн үг. Ер нь тэгээд манай ардчиллынхаа индексээр тэр алдаатай ардчилал гэдэг ангилалд ороод байгаагийн гол шалтгаан нь энэ.

Тэгээд энэ дээр энэ 50, 50 болон гишүүдийн тоо тодорхой хэмжээнд нөлөө үзүүлэхээр ийм тооцоо харагдаж байгаа юм.

Н.Энхболд: Баярлалаа. Сүхбаатар гишүүн. Засгийн газрын гишүүн чинь одоо хэнээс асуух вэ?

Ж.Сүхбаатар: Өглөөний мэнд хүргэе. Тэгээд өнөөдрийн энэ орж ирж байгаа асуудал Засгийн газар өргөн барьсан. Би Засгийн газрын гишүүн.

Гэхдээ нөгөө үүх түүхийг нь ярих хэрэгтэй байгаа юм. Энэ асуудлаар бас зөв ойлголт өгөх ёстой. Хүмүүст. Энэ бол бас олон нийтийн санаа бодолд янз бүрийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

бодол төрж, эсрэг тэсрэг асуудлууд үүсэж байсан асуудлууд.

13 жилийн өмнө анх би олон нийтэд хандаж 1 удаа ярилцлагадаа хавчуулж байсан юм бол парламент маань бүрэлдэхүүн цөөн байна. 99 гишүүнтэй байвал зохимжтой юм байна гэж анх дуугарсан хүн байхгүй юу. Тухайн үед Их Хуралд байхад би энэ санаа бодлоо одоо энэ Нямжавын Батбаяр буюу Фортуна гэдэг гишүүнтэй анх ярилцаж байсан ийм түүхтэй. Тэгээд намайг ганц дэмжсэн хүн маань тэр. Нэлээн олон улсууд намайг тэр үед ийм бүтэхгүй юм ярилаа гээд. Тэгээд нэг ярилцлага өгсний дараа нэлээн олон сэтгүүлч ч шүүмжлэлтэй хандаж байсан юм.

Тэгээд 2011 онд “News.mn”-д 5 сард ярилцлага өгч байсан. Ер нь 99 гишүүнтэй байх нь зохимжтой гэж. Яагаад гэвэл тэр үед нөгөө Сонгуулийн хууль хэлэлцэж байсан юм. Тэгээд ер нь цаашидаа ингээд явах ёстой гэж.

Сүүлд хэдэн жилийн өмнө давжаа парламент гэж Үндэсний олон нийтийн телевизэд ярилцлага өгөхдөө хэлсэн. Энэ маань олон хүнд хүрсэн. Монгол Улс давжаа парламенттай байна гэж. Тэгээд юу юм бэ гэхээр энэ ард түмний олонхын засаг гэдэг бол “парламентаризм” гэдгээр илүү их илэрдэг. “Демокраси” гэдэг бол олонхын засаглал гэж орчуулагддаг. “Демократис” гэж. “Олон түмний засаг” гэж. Яах вэ, зарим нь “олонхын засаг” гэдэг. Гэхдээ ардчиллын сүүлийн үеийн философиороо “ардчилал” гэдэг бол олонхоор удирдаж цөөнхийг хамгаалдаг засаглалын механизм гэж ингэж тайлбарладаг.

Тэгэхээр орчин үед хоёр хандлага байгаа юм. Сонгууль дээр.

Нэг нь, хэлэлцээрийн буюу зөвшилцлийн ардчилал гэж Европын загварын сонгуулийн тогтолцоо байгаа юм. Энэ нь ялагч намыг тодруулахаасаа

илүүтэй бодлогын хөтөлбөрийн намыг гаргаж ирэх.

Өөрөөр хэлбэл ард түмний төлөөллийг илүү тодруулж парламентад тусгалыг нь олох зарчмаар пропорциональ систем давамгайлсан энэ хэлбэрийг Европт илүү тавьж байгаа. Энэ нь илүү их зөвшилцсөн эсрэг тэсрэг олон намуудыг оруулж ирж үндэсний зөвшилцлийг хүргэх механизм дээр илүү ажилладаг.

Англо-саксоны орнууд буюу холбооны томоохон улсууд дээр харин мажоритар системийг давамгайлуулдаг. Тэр нь юу юм бэ гэхээр Англо-саксоны орнууд их биеэ даасан хотуудтай, мужуудтай байдаг.

Өөрөөр хэлбэл эс төвлөрөл буюу “decentralization” гэдэг тус тусдаа бараг улсаасаа дутахгүй тусгай. Одоо батлан хамгаалах, гадаад бодлого хоёроосоо бусдаар биеэ даасан хот, мужуудтай байдаг.

Тэгэхээр тэр хот, мужууд гэдэг нь тухайн улсыг задалж өгч байдаг. Нэг талдаа задарсан болдог. Тэгэхээр үндэсний хэмжээнд буюу холбооны түвшинд нь мажоритар систем буюу хоёр улс төрийн зонхилгогч хүчинд хуваах замаар үндэсний хэмжээний зөвшилцөл нэгтгэлийг хоёр хүчинд хуваах замаар бий болгодог ийм сонирхолтой механизм байгаа. Ийм хоёр талын өөр юм байгаа юм.

Тэгэхээр манай нөхцөлд энэ мажоритар систем давамгайлаад явчихаар нөгөө эс төвлөрсөн биш нэгдмэл, төвлөрсөн, хүчтэй улс учраас бүх түвшинд нутгийн өөрөө удирдах байгууллага нь сул учраас энэ хоёр улс төрийн хүчинд хуваагдахаараа дээрээсээ цуу доошоо хуваагдчихдаг. Англо-саксоны тэр холбооны том орнуудад доошоогоо хуваагддаггүй. Хотууд нь, мужууд нь өөрийн удирдлагатай учраас тэр нэг их ач холбогдол нь бага байдаг, сул байдаг.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Манайд болохоор улс төрийн хүчин ялагч бүхнийг авна гэдэг зарчмаар орчихоор сонгууль нөгөө алаан болж хувирдаг. Сонгуулийн өрсөлдөөн гэдэг бол тэмцэл болдог. Орсон хойноо 2 улс төрийн хүчин бол эвлэршгүй буюу нэг нь бүх эрх мэдлийг авсан, нөгөөдөх нь юу ч үгүй хоосон хоцорсон болдог.

Гэтэл Европын орнуудад сонгуульд ороод тодорхой хувийн санал авсан, ялагдсан гээд байгаа нам, нэр дэвшигчиддээ компенсац өгдөг шүү дээ. Одоо 10 хувийн санал авчихсан, 20 хувийн санал авчихсан хүнд сонгуулийн зардлынх нь хэсгийн тодорхой хувийг өгдөг байхгүй юу. Энэ яаж байна вэ гэхээр нийгмийн тэр их зөрчилдөөнтэй, өрсөлдөөнтэй, тэмцэлдээнтэй байдлыг багасгаж намжааж өгдөг.

Тэгэхээр энэ асуудлуудыг би яагаад хэлж байгаа юм гэхээр манай 76 гишүүн гэхээр манай улс орны бүх баялгийн гол хуваарилалтыг, төсвийг, томилгоог гол хийж байгаа газар нь парламент болчихсон.

Тэгэхээр 76 хүнтэй. Нөгөө хуучин Улс төрийн товчоо 9 хүнтэй байсан бол тэрийгээ 76 болгочихсон. 50 хүнтэй Бага хурал байж болсон. Гэтэл 430 хүнтэй Ардын Их Хурал байж байсан. Сүүлдээ эрх мэдлийн төлөө тэмцэл болоод эхэлсэн. Дотроо. Иргэдэд нэг их харагдаагүй.

Тэгэхээр бушуухан Ардын Их Хурал, Бага Хурал хоёроо тараагаад тэгээд нэг танхимтай парламент байх ёстой юм байна гэдэг энэ шийдэл гаргасан тухай Чимид багш тайлбарлаж байсан байгаа юм.

Тэгэхээр одоо манай 76 яачхаад байна вэ гэхээр 2005 оныг хүртэл Монгол Улсын төсөв маш бага байсан юм. 500, 600 сая долларт л эргэлдэж байсан байх. Тэгэхээр хэдэн их наядаар эргэлддэг, хэдэн тэрбум долларын хэмжээтэй төсөв хуваарилж байна. Улс орны нийгмийн

хэмжээнд маш олон иргэний нийгмийн бүлгүүд бий болчихсон. Урьд нь иргэний нийгэм гэхэд ахмад, залуучууд, эвлэл гээд хэдхэн. Эмэгтэйчүүд гээд явж байсан бол сувилагчдын, одоо тэгээд жишээлбэл гагнуурчдын ч гэдэг юм уу, малчдын, хоршоологчдын гээд маш хүчтэй нийгмийн олон бүлгүүд бий болоод ирсэн. Эрх ашгаа мэдэрсэн.

Энэ олон эрх ашгууд хоорондоо угаасаа зөрчилдөөнтэй байдаг. Ардчилсан нийгэм өөрөө зөрчилдөөнөөр дүүрэн буюу эрх ашгийн зөрчлийг үгүйсгэдэггүй. Тэгэхээр үүнийг үндэсний хэмжээнд зангиддаг газар нь юу юм бэ гэхээр парламент. Тэгэхээр одоо манай парламентын гишүүдийг жишээлбэл Их Хурлын гишүүн гэж нэрлээд байгаа юм. Үүнийг бусад оронд “ард түмний төлөөлөгч” байхгүй юу.

Тэгэхээр бид гишүүдийн тоог нэмэгдүүлнэ гэж ярихаар дарга нарын тоо, гишүүн даргын тоог нэмэгдүүлнэ гээд байгаа юм.

Одоо энэ философиор гишүүдийн тоог би анх 99 гэж ярьж байхдаа цаашаа юу бодсон юм бэ гэхээр энэ бол “дарга гишүүн”-ээс “төлөөлөгч гишүүн” рүү шилжих шилжилт гэж ингэж үзэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл олон гишүүнтэй болох тусам эрх мэдэл олон хүнд шилжинэ, бие биеийгээ хянан тэнцвэржүүлнэ.

Хамгийн энгийн жишээг би зарим сонгогчдодоо тайлбарлаж байсан. Одоо 20 хүүхэдтэй ангид нэг багш тулж ажиллах, 50 хүүхэдтэй тулж ажиллах хоёр өөр байгаа. Хүмүүс ч гэсэн гомдоллож байгаа. Яагаад гэвэл багш 50 хүүхэдтэй болохоор тулж ажиллаж болохгүй болчихоод байна гэж байгаа. Яг түүнтэй адилхан эсрэгээрээ парламент дээр 99 гишүүнтэй тулж ажиллах, 76 гишүүнтэй тулж ажиллах хоёр дээр чанарын ялгаа гардаг. Яагаад гэвэл нэг

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хүний үзүүлэх нөлөө зарим судлаачдын тогтоосноор 15 гишүүнд буюу 20 хүртэл хүнд нөлөөлж болдог гэж үздэг.

Тэгэхээр одоо 76 дээр жишээлбэл энгийн нь манай дээр 3 гишүүн нийлэхэд үндсэндээ парламентад маш хүчтэй нөлөө үзүүлж болдог байгаа юм. Үүнийг ядаж 10 хүртэл болгох шаардлага бий. Үүнийг хамгийн энгийн ухаанаар бодохоор.

Хүмүүс цөөлөхөөр сайжирна гэж байгаа юм. Одоо урд талын Хятадын Коммунист Намын Улс төрийн товчийг 9 байсныг өмнөх хуралдаанаар 7 болгосон шүү дээ. Тэгээд тэр нь юу гэж байна вэ гэхээр гаднын экспертүүд эрх мэдэл олон хүнд байхаар их зовлонтой юм байна. Бие биедээ хяналт тавиад. Тэгэхээр дотоод хяналт, тэнцлийг яаж бий болгох юм гэхээр тэд хүмүүсийнхээ тоог, бүрэлдэхүүнийг нь өргөтгөх замаар зөрчилдөөнтэй, сайн муутай олон хүнийг оруулж ирээд хуйвалдах боломжийг байхгүй болгоод тараадаг.

Нэг хэсэг нь хэрвээ бүлэглээд хуйвалдвал нөгөө хэсэг нь тэрний эсрэг нам дотроо бусад намын эсрэг явдаг. Ийм дотоод хяналтын зөрчилдөөнтэй механизмыг энэ өөрөө олон тоо агуулж байгаа юм. Судлаачдын хэлэхэд энэ ер нь 130-аас дээш болох юм ер нь цөөн дарга нар засагладаг замбараагүй олонхыг хянадаг болдог гэж нэг үздэг. Бас 100-аас доош байх юм хэт цөөнхийг бас цөөн хүн базаад байхад бас хянаад зохицуулаад байх боломжтой гэж үздэг гэж энэ 2010 онд би яахдаа бас өөрийнхөө энэ тоог нотлох гэж ингэж уншиж байсан. Тэгэхээр миний сан юу юм гэхээр анх 13 жилийн өмнө 99 байжээ. Дараа нь Одбаяр гишүүн бол яах вэ албан бусаар, гишүүдэд үгүй ээ, үгүй 108 байна байх нь зохимжтой гэж ингэж миний 99, 108 гэдэг 2 тоо 10 жилийн өмнөөс эргэлтэд орсон түүхтэй. Тэрийг нь дараа нь Фортуна гишүүн бол дараа нь телевизээр 99-ийг арай өөр бэлгэдлийн шинжтэй

тайлбарлагдаад ингээд гуйвуулагдаад явчихсан юм байдаг юм.

Тэгэхдээ бид бол яах вэ тухайн үед 3 оронтой тоонд оруулахгүй хязгаар нь 99 юм. Тэгээд манай парламент чинь 3, 4 гэдэг тоонд хуваагддагаар санал тоолдог байхгүй юу. Тэгэхээр 3, 4 гэдэг дээр чинь 99, 108, 123 гэсэн тоонууд таардаг юм. Ер нь 125-аас дээш болохоор асуудал үүсдэг гэдэг яриа байгаа. Тэгээд би товчхон хэлэхэд иргэд их олон янз байгаа. Энэ хэлэлцүүлэг.

Н.Энхболд: Сүхбаатар гишүүн санал, тайлбар хэллээ. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

1992 онд Ардчилсан Үндсэн хууль байгуулагдсанаас батлагдсанаас хойш 8 удаагийн сонгууль боллоо. Энэ 8 удаагийн сонгуулийн бүхий л системүүдийг туршиж үзлээ. Жижиг мажоритар, томсгосон олон мандаттай, мажоритар, холимог гулсдаг. Байж болох хувилбаруудыг бүгдийг л үзсэн л дээ. Гэхдээ энэ 8 удаагийн сонгуульд одоогийн эрх баригч хүчин үндсэндээ 7 удаа эрх барьсан. Ардчилсан намын хувьд 1996 онд л нэг яг олонх болж чадаагүй тэгэхдээ эрх барьж байсан. Тэгээд бусад нөхцөл байдлыг бол эрх баригч нар яг л сонгуулийн өмнө Сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах замаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах замаар л явж ирсэн. Тэгээд өнөөгийн болж бүтэхгүй зүйлээ ингээд Үндсэн хууль руу хийж ярьдаг ийм л зүйл байгаа юм. Тэгээд одоо бол нэг Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гэж ингэж яриад байгаа юм. Тэр Үндсэн хуулийн шийдвэрийг харахад энэ Үндсэн хуулийн цэц чинь ер нь чадамжтай юм уу? Түүхийг нь хараад байхад Ардчилсан нам ялсан он жилүүд буюу эрх барьж байгаа он жилүүдэд давхар дээр болохгүй, Ардын нам ялангуут болно. Болно, болохгүй, болно, болохгүй гээд. Ээрэг муураг, ээрэг муураг гэж явдаг.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Дандаа эрх баригчдын захиалга гүйцэтгэдэг ийм хүмүүсийн дүгнэлтээр явж болох уу гэсэн.

Дараагийн нэг асуудал 2019 оны Үндсэн хуулийн үргэлжлэл гэж энэ хүмүүс яриад байх юм. Та нар ингээд ой санамжгүй болчих юм. 2019 онд Үндсэн хуулийн өөрчлөлт хийгээд та бүхэн Бүрэн зураглал гэж нэвтрүүлэг хийгээд үнэхээр төгс хууль боллоо гэж байсан. Монголын ард түмэн та нар одоо жаргана. Бид нар ёстой өнгөрсөн 20,30-аад жилийн хугацаанд энэ бодож байсан зүйлээ энэ Үндсэн хуульд л нэг оруулж авлаа. 4 сайд давхар дээлтэй байж болно. Бусад нь бол дан дээлтэй байх хамгийн хүмүүст таарсан энэ зүйлийг хийлээ гэсэн. Ингээд гаднаас хараад байхад 2016 оноос хойш 65-ын бүлэг, 62-ын бүлэг хэт олонхын засаглал тогтоож, ардчилал хумигдаж, хүний эрхийн асуудлууд, хувийн өмчийн асуудлууд гээд ингээд олон ээдрээтэй зүйлүүд гарч ирж байгаа юм аа.

Ингээд нөхцөл байдал хүндрээд ирэнгүүт дахиад 2020 онд 62-ын бүлэг гарч ирээд давхар дээлийн асуудлыг ярьж ирж байгаа юм. Нөгөө төгс төгөлдөр хууль жил гаруйхны дараа төгс биш болж байгаа юм. Ингээд давхар дээл нь сайн юм болов уу гээд бодоод үзэхлээр давхар дээлтэй энэ сайд нар ерөөсөө чихгүй толгой болчихдог.

Өнөөдөр энэ парламентыг эхлэхэд 4 сайд анхнаас давхар дээлтэй байсан. Бусад сайд нар хэний хүчээр ямар намын хүчээр давхар дээл өмссөнөө мэддэггүй. Зүүдэнд нь ч орохгүй байгаа. Ерөөсөө чихгүй толгойнууд. Цаашилбал энэ чихгүй толгойнууд ингээд бүүр Үндсэн хуульд өөрчлөгдөх нь л дээ. Аягүй бол нүдгүй толгой болно. Ийм байдлууд дээр юмнууд олон талаас нь ярих ёстой байх гэж бодож байгаа юм. Тэгэхдээ алив зүйлийг хийхэд өмнөх зүйлээ дэндүү харлуулж муулах нь буруу. Би мажоритар системийн сайн талууд байдаг гэж үздэг.

Өнөөдөр 1990-ээд оны эхээр шилжилтийн үед аймгуудад очиход ямар байлаа, сумдад очиход ямар байлаа. Гэрэл гэгээ байхгүй, хөлдөж хөрсөн, хог нохойндоо дарагдсан зүйл байсан. Тэгвэл энэ тойргийн систем, мажоритар систем, мөн орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгээр өнөөдөр манай аль ч аймагт очсон, аль ч сумд очсон бас нэг хүний нүүр харахтайгаа болсон ийм зүйлүүд байдаг. Холимог системийг, гулсдаг системийг 2012 онд туршиж үзэж байсан. Тэр үед хамгийн л олон орлоо, гарлаа, нийллээ, саллаа гэсэн. Энэ төрийн хамгийн гутамшиг тэр он жилүүдэд явж байсан шүү дээ.

Энэ зүйлүүдээ бас олон талаас нь ярих ёстой байх гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд манай намын хувьд Үндэсний бодлогын хороо нэлээн халуун болсон. Мэдээж 3 жил шахуу бид ямар байсныг Монголоороо мэдэж байгаа. Биднийг ямар байлгаснаа ч бас та бүхэн өөрсдөө санаж байгаа байх. Тэгээд Үндсэн хуулийн өөрчлөлт явах шаардлагатай болохлоор бас бид хэрэгтэй л байгаа байх.

Гэтэл тэнд юу ярьсан бэ гэхлээр Үндсэн хуулийг бас өөрчилье гээд байна. Нийгмийн сайн сайхны төлөө зүтгэе гээд байна. Энд нь бас оролцье. Оролцохдоо иргэний эрхийн асуудал, хүний эрхийн асуудал, засаглалын асуудал, энэ Үндсэн хуулийн цэцтэй холбоотой асуудал энэ тэрийг багцаар нь оруулъя гэж бид нар өдөржин шөнөжин хуралдаж байгаад 5 багц асуудал өгсөн. Энэ 5 багц асуудлаас хувь тэнцүүлэх пропорциональ л орж ирж байх шиг байна. Бусдыг нь нүд аньсан, сонсоогүй. Бидний үгийг сонсохгүй байна гэдэг бол та нар 40 гаруй хувийн сонгогчдын саналаар төрийн 100 хувийн эрх мэдлийг барьж байгаа юм. Ерөнхийлөгчтэй нь, Засгийн газартай нь, Их хуралтай нь бүх гүйцэтгэх байгууллагатай нь.

Тэгэхээр бидний энэ саналыг хэлэлцүүлгийн явцад оруулах уу, оруулахгүй юу? Та нарын пропорциональ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

элементийг чинь авч байгаа юм гээд нөгөө гуя дагаж хүзүү гэдэг шиг. Тоогоо 152 болгоод аваад ирлээ. 152-ыг тайлбарлахдаа үгүй ээ, юу ч хамаагүй ярьж байна. Хүний тоотой хуваарилна ч гэх шиг. Сая тэндээс хэн гэдэг хүн юм тэр нэг. Үгүй ээ өнөөдөр тэрбум гаруй хүнтэй Хятадыг удирдаж байгаа хүмүүсийг хүний тоонд нь харьцуулах, Энэтхэгийг удирдаж байгаа хүмүүсийг нь хүний тоонд харьцуулах, Монголыг харьцуулахад эднүүдээс мангар том засаглалтай байгаа шүү дээ. Энэ том газар нутаг дээр энэ цөөхөн хүн амыг бид нар чинь юун тэрбум 100 сая ч хүрэхгүй. Гурван саяхан хүмүүс. Ингэхээр тэр Америкийг бодоод байсан. Америк чинь 200, 300 сая хүнтэй. Тэгэхэд нэг хэдэн хүн төр барьж байна. Оросыг хар. Тэгэнгүүт аль болохгүй жижиг улсуудын хуваарийг авчраад тэгээд ингээд гөлөг төөрүүлж байг юм шиг янз бүрийн юмнууд яриад байдаг.

Тэгэхээр алив зүйлийг сайнтай муутай нь хэлэлцэж байж хэдүүлээ сав дүүрдэг. Сая энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлгүүд Монгол телевиз бусад телевизээр явуулахад, жишээ нь намайг ганц ч удаа оролцуулахгүй байгаа байхгүй юу. Тэнд оролцоо гээд би хэллээ гээд эсрэг болчихгүй л дээ. Хэдүүлээ сайн муу талаас нь зүгээр ярилцаад явах юм бол үнэхээр тэр 2019 онд яриад байсан шиг чинь төгс хуульч болох юм болов уу яаж мэдэх вэ дээ. Тэгээд төгс гээд л өөрчлөөд байдаг, төгс гээд өөрчлөөд байдаг. Төгсийн төгс гэж байдаг юм уу? Энэ зүйлүүдээ хэдүүлээ хамтдаа яриад тэгээд энэ асуултуудад хариулт өгсний дараа би ахиад тодруулъя л гэж ингэж бодож байна.

Н.Энхболд: Нямбаатар сайд дундуур нь шинэ саналууд гарч ирвэл хүлээж авах боломж бий юу гэж.

Х.Нямбаатар: Би Батсуурь гишүүний асуултад сүүлийнхээс нь эхлээд хариулъя.

Ардчилсан намын зүгээс 5 бүлэг, 18 зүйл бүхий Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг ажлын хэсэгт ирүүлсэн. Манай ажлын хэсгийн гишүүд болох манай намын бүлгийн дарга Тогтохсүрэн гишүүн, ЗГХЭГ-ын дарга Монгол Улсын сайд Амарбаясгалан бид хэд ажлын хэсэг дээр Ардчилсан намын бас энэ саналыг ярилцсан. Ардчилсан намын гишүүдтэй. Саналд цаашид парламентын ардчиллыг төгс боловсронгуй болгох Монгол Улсын Үндсэн хуулиар засаглал хуваарилах сонгодог зарчмыг төгсрүүлэх ийм олон саналууд ирсэн. Үүнээс гадна Зөвлөлдөх санал асуулга болон иргэд судлаачдаас зөвхөн зөвлөлдөх санал асуулгын хүрээнд 33 мянга гаран бас санал энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулъя гээд давхардсан тоогоор ирсэн.

Бусад улс төрийн хорин хэдэн намуудаас ч гэсэн саналууд ирсэн.

Тэгэхээр энэ удаагийн өөрчлөлтийг дахиж онцолж хэлэхэд энэ бол 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үргэлжлэл болж явж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд таны хэлж байгаагаар та ч сая нийгэм улс төрийн хэллэгт их олон тийм шинэ нэр томъёонууд оруулж ирж байна. Хэт олонхын дарангуйлагч засаглалын үед хэт их өөрчлөлт оруулах нь зохимжгүй гэж манай нам үзсэн.

Тэгэхээр 2019 оныхоо нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд тоогоо нэмэгдүүлье шинэ парламент, илүү олон намын төлөөлөлтэй нийгмийн бүлгүүдийн төлөөлөлтэй бүрэлдэх байх тэгээд шинэ парламент нь цаашид нийгмийн гэрээндээ өөрчлөлт оруулах эсэхээ шийдье ээ гэж үзсэн.

Тийм учраас энийг парламентаар зөвхөн тоо тогтолцооныхоо асуудлыг хэлэлцүүлье.

Хоёр гэвэл бид нар Үндсэн хуулийн цэцээс гаргасан Цэцийн шийдвэр Улсын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Их Хурлын 54 дүгээр тогтоолыг Засгийн газар хэрэгжүүлж байгаа гэдгийг хэлье.

Би яагаад сая Батсуурь гишүүний хэлсэн нэг үгэнд нэлээд эмзэглэж ер нь сүүлийн үед их олон удаа энэ телевиз, радиогоор манай сөрөг хүчний зүгээс гараад байгаа юм л даа. Хэт олонхын дарангуйлагч засаг гээд. Тэгээд жишээлэхэд 1955 онд Японы Либерал Ардчилсан нам үүсгэн байгуулагдсан байх жишээтэй. Энэ 67.8 жилийн хугацаанд Либерал Ардчилсан нам засгийн эрхийг бараг бүхэлдээ барьсан.

Энэ хугацаанд 2006-2008 онд билүү нэг сөрөг хүчиндээ Засгийн газар алдсан. Бусад он жилүүдэд бүхэлд нь Японд либерал Ардчилсан нам нь доминант парти болж энэ засгийн эрхийг гарт барьж байгаа юм. Гэсэн хэдий ч сөрөг хүчин нь дарангуйлал тогтлоо гэж НҮБ-д хандаж тийм улс төрийн акц хийж байсан гэж би лав сонсоогүй. Япон, Герман гээд энэ тогтвортой эдийн засаг нь эрчимтэй хөгжиж байгаа улс орнуудад энэ тогтвортой засаглах гэдэг бол байдаг үзэгдэл. Герман 2005-2021 он хүртэл Христосын Ардчилсан нам засагласан байх жишээтэй.

Зүгээр би энийг энд зориуд хэлэхийг хүслээ. Тооны тухайд хүн амын тоотой харьцуулбал энэ харьцангуй ойлголт болно оо. Манай тэр 5 номерын микрофон дээр сууж байгаа ажлын хэсгийн гишүүн энэ үндэслэлийг ярихдаа эхлээд нэр албан тушаалаа яриад, судалгаа үндэслэлээ маш товчхон ярихгүй бол болохгүй.

Хоёр гэвэл би ажлын хэсгийнхэнд нэг анхааруулж хэлье. Та хэд өрсөлдөж гар өргөж хариулдаг зүйл биш. Энэ Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журам энэ тэр өөр. Зөвхөн хуралдаан даргалагч хариул гэсэн тохиолдолд хариулна. Сая та нар ингээд өрсөлдөж хариулт өгөх гээд байх шиг байна лээ.

Тооны тухайд Батсуурь гишүүн ээ 1.3 миллиард хүн амтай Хятад 3.4 сая хүн амтай Монгол 2 хүн амынхаа тоонд харьцуулсан засаглалтай байна гэдэг бол энэ хэзээ ч дэлхий дээр байж болохгүй зүйл. Аливаа улс орон өөрийн гэсэн төрийн институц гэж байдаг.

Тэр институцийг засаглал хуваах онолын дагуу удирдан зохион байгуулахдаа парламентын засаглал нь хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлэхэд ойролцоогоор ийм тоо тогтолцоотой байна гэдэг ийм шалгуур үзүүлэлт дээр л суурилж байгаа юм. Тэрнээс биш 1.3 миллиард хүн амтай улсад парламентын гишүүдийг татаад тоог нь тавивал энэ ерөөсөө боломжгүй зүйл. Тухайн улс орнуудад хүн амын тоотой уялдсан публик сервис гэдэг ойлголт байдаг. Энэ публик сервис. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн тухайд энэ өөрөө тухайн төрийн институцдээ тохирсон ийм тоо хэмжээтэй байдаг аа. Тэр утгаараа бид энэ тоог нэмэгдүүлэх шаардлага гарч ирсэн. Би таны туслахад өгсөн. Та харсан болов уу, үгүй болов уу? 1991 оны энэ Улсын бага хурал дээр Монголын Үндэсний дэвшлийн намаас хийлгэсэн суурь судалгааг би парламентын номын сангаас шүүлгээд зохиогчоос нь зөвшөөрөл авч байгаад хэвлэх үйлдвэрт хэвлүүлээд гишүүн нэг бүрд тараалгасан юм аа.

Тэр үед 76 гэдэг тоо яаж гарсан талаар тэр бүүр тухайн үеийн яг бодит судалгааны материал байгаа. Манай бүх гишүүд энийг нэг олж үзээрэй гэж би хэлэх гэсэн юм. Тэр үед ерөөсөө 23 мянган хүнийг иргэнийг парламентын гишүүд төлөөлье өө гэдэг ийм шууд автомат тоо тавигдаад явсан. Хүн амын тоо 3.4 болсон. Улс орон бүс нутгуудын хөгжил харилцан адилгүй байгаа. Төв суурин газруудын сонгогчийн тоо илүү байгаа энэ тэр олон зүйлүүд шалтгаалсан. Тэгээд бид бүхэн энэ өнгөрсөн 10 гаран жилийн хугацаанд Их Хурлын гишүүдээс гарсан олон удаагийн Үндсэн хуульд нэмэлт,

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

өөрчлөлт оруулах төслүүдэд дүн шинжилгээ хийж үзсэн.

Мөн эрдэмтэн судлаачид математик тооцооллуудыг хийж үзсэн. Улс орнуудын төрийн институцид хууль тогтоох эрх мэдлийн гүйцэтгэх үүрэг роль зэргийг харгалзан үзэж 152 гишүүн хамгийн боломжит парламентын ардчиллыг бэхжүүлэх, парламентын засаглалыг хүчжүүлэх, нэг гишүүнд ноогдох эрх мэдлийн жинг бууруулах ийм тоо байна гэж эрдэм хүндэтгэн гаргаж ирсэн тоо судалгаан дээр үндэслэж өнөөдрийн энэ тоог оруулж ирсэн гэдгийг хэлье.

Тэгэхээр танай намаас ирүүлсэн 5 бүлэг 18 саналыг бид нар яг дээр дурдсан байдлаар хариулна. Шинэ парламент энэ нийгмийн гэрээндээ өөрчлөлт оруулах эсэх асуудал нь шинэ парламентын шийдэх асуудал. Нэг нам олонхоороо дийлэнх олонхыг бүрдүүлж байгаа үед Үндсэн хуульд олон суурь өөрчлөлт оруулж реформын шинэчлэл хийх нь сөрөг үр дагаврыг дагуулна.

Нөгөө легитим тэр шинж чанар алдах магадлал байгаа учраас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт Улсын Их Хурлын тогтоолынхоо дагуу өнөөдөр зөвхөн тоо тогтолцоог оруулж ирж байгаа. Шинэ парламент дараагийнхаа асуудлыг шийдэх байх аа.

5 номерын микрофон дээрээс нэмэлтээр энэ тоон дээр математик ямар тооцоолол хийсэн талаар нэг товчхон нэмээд хариулчихъя.

Н.Энхболд: Тоо ч түрүүн ярьчихсан даа. Товчхон хэлчихье.

Бумдарь 5 номер микрофон.

Д.Бумдарь: Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Бумдарь гэж хүн байна. Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Хоёр талаас нь тайлбарлая гэж бодож байна. Тоог бол парламентын хэмжээ нэг гишүүний төлөөлөх иргэдийн хэмжээ гэдэг ийм 2 хэлбэрээр бол тооцож олдог байгаа. Тэгэхээр парламентын хэмжээ гэдэг нь болохоор саяын яриад байгаа тэр 152, 137, 162 гэсэн тоонууд буюу куб аргачлалаар боддогийг нь хэлээд байгаа.

Тэгэхээр зэрэг энэ маань ямар утгатай юм бэ гэх юм бол парламент зохистой ажиллах тэр харьцааг л олдог тоо гэсэн үг. Тэр зохистой ажиллах харилцаа нь 152 гарч байна гэж ойлгож болно. Парламентын тэр нэг гишүүний төлөөлөх тооны иргэдийн тооны асуудал зөвхөн өнөөдөр яригдаж байгаа зүйл биш. Энэ 1793 онд Америкт гарсан мандатын тоо гэдэг хууль байдаг. Анпойтмент билл гээд үүндээ тусгасан байдаг. Юу тусгасан байдаг вэ гэх юм төлөөлөгчдийн тоо нь 30 мянган иргэн тутамд нэгээс илүүгүй муж бүр нэгээс доошгүй төлөөлөгчтэй байна гээд заачихсан байдаг гэсэн үг.

Тэгэхээр 1790 хэдэн оноос энэ нэг гишүүн хэдэн иргэнийг төлөөлөх вэ гэдэг нь гарч ирсэн ийм үндэслэлтэй байгаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүн 2 минут, нэг удаа 2 минут. Дэг тийм нэг удаа 2 минут.

Ж.Батсуурь: Үгүй ээ яах вэ бид нар хэлэлцүүлэг хийж байгаа гэж ойлгож байгаа шүү дээ. Хэлэлцье гээд байгаа байхгүй юу. Хэлэлцье гээд орж ирчхээд байгаа юм. Тэгээд 1 асуудал хэлэлцье гэдэг чинь 2 талаас хэлэлцэхийг хэлдэг.

Тэгэхгүй одоо ингээд нэг угаах замаар яваад байгаа байхгүй юу. 1700 оныг ч яриад л, тэгээд л онол яриад л болох бүтэхгүйгээ ярьж байгаад сайныг гаргахыг хэлэлцүүлэг гэдэг болохоос биш саяын телевизүүдээр явсан бүх хэлэлцүүлэг хүмүүсийн толгойг угаасан. Ерөөсөө бүх юм өмнөх юмнууд баба байсан, одоо ёстой гоё, гоё юм гаргана

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

гээд. Ингээд байгаа байхгүй юу. Би хэлээд байг шүү дээ 2019 онд төгс боллоо гээд байсан. Бүүр та нар бүгдээрээ зогсчоод мэдээлэл хийж байсан. Тэгээд одоо төгсийн төгс юм хийх гээд байг юм уу гэж.

Дээр нь ингэж байгаа юм. Засаг барина гэдэг бол урлаг, итгэлцэл. Нямбаатар сайд бид нар залуу хүмүүс бас шинэ зүйл оруулж ирж байгааг ойлгож байна. Мэдэж байна. Гэхдээ хэлсэндээ байгаарай. Ярьсандаа байгаарай. Хэлж ярьсандаа байхгүй бол нөгөө эхнэр нөхөр байтугай эрүү толгой 2 салдаг гэдэг шиг бас яривал ярих, хэлбэл хэлэх юмнууд байгаа шүү. Ер нь зүгээр ярилцъя хэлэлцье. Тэгэхээс зүгээр нэг бялдаад явчихъя энэ тэр гээд байх юм бол бас бид нарт ч ярих цаг зав байна. Ард түмэнтэй ч бас хэлэх ярих зүйлүүд байгаа. Тэгэхдээ хамтдаа хэлэлцье. Мэдээж сайн сайхныг хамтдаа бүтээхийн төлөө явъя. Бялдаад явах юм бол энэ давхар дээлтэй хэдэн сайд нар шиг байгаа болох юм бас бид нар цаашаа явахад хэцүү л байх. Ойлголцоод мэдрээд байх юм бол дахиад давхар дээл өмсүүлсэн ч болно шүү дээ. Нэмнээ өмсүүлсэн ч болно. Ийм зүйлүүд байгаа.

Н.Энхболд: Батсуурь гишүүн санал хэллээ.

Оюунчимэг гишүүн асууя.

М.Оюунчимэг: Бид нар энэ Улсын Их Хурал парламент гэдгийг нэг тооноос бүрдэх тооноос шалтгаалдаг юм шиг л ингээд л онолоор тайлбарлаад байна л даа.

Парламент гэдэг бол ард түмний засаглал шүү дээ. Ард ард түмний төлөөллийг хангаж чадах тэр төлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг тэднийг төлөөлж чадах чадвартай хүмүүс л Улсын Их Хурлыг бүрдүүлдэг. Тэгээд Монголын ард түмэн чинь ер нь ухаантай шүү дээ. Олон нам байх ёстой гэж үзвэл өөрсдөө сонголтоо хийчихдэг. Үгүй ээ энэ нь ч болохгүй байна

эд нар чинь хоорондоо хэрэлдээд байна. Ер нь нэг нам нь ингээд тогтвортой улс орноо аваад явчих гээд л бас өөрсдөө сонголтоо хийчихдэг ийм л ард түмэн шүү дээ. Одоо жишээ нь 2 удаа МАН-ыг 62, 65 гэж сонгосон нь энэ ард түмний л сонголт. Тэрнээс биш нэг намын дарангуйллыг хүчээр хийчихсэн юм шиг тийм онолоор тайлбарлаад байх шиг буруу юм байхгүй шүү дээ.

Өөрөөр хэлбэл ард түмний сонголтыг бараг үгүйсгэх гэсэн оролдлого гэж би бол энийг харж байгаа. Тэгээд албаар 152 болговол тэгээд л ингээд л олон намын төлөөлөл болоод л улс орон сайхан болчих юм шиг Их Хурлын гишүүдийн ачаалал нь тэнцвэржээд л авлигал хээл хахуулиас хол байчих юм шиг л яриад байх юм. Тийм юм байхгүй шүү дээ. Харин ард түмэн маань хэнийг сонгохоос төлөөлж чадах чадвартай яг энэ төрийн үйл ажиллагааг түмнийхээ төлөө ажиллаж чаддаг хүнээ сонгох нь өөрөө энэ тооноос илүү чухал. Энийг бид нар бол хаана хаанаа маш сайн анхаарах хэрэгтэй. Тэгэхгүй ингээд л 152 юм уу 50, 50 болчихвол улс орон хөгжчих юм шиг юм яриад байх юм. Өмнө нь бас тэгж явж ирсэн түүх байгаа шүү дээ?

Юмыг бас сайн судалж байж түүхээ эргэж харж байж бас ярих нь их чухал шүү гэдгийг хэлмээр байна. Одоо жишээ нь Япон улсыг жишээ авч байна бид нар. Япон улс үнэхээр өндөр хөгжилтэй тогтвортой улс. 60, 40 гэсэн харьцаатай байгаа. Гэхдээ энэ 126 сая хүн амтай улс манай улс 3.5 орчим сая хүн амтай төлөөллөө аваад үзэхэд тойргийн төлөөлөл буюу энэ мажоритар нь бас өөрөө хэрэгтэй.

Өнөөдөр ХБНГУ Бундестаг саяхан бид нар бас ингээд ажиллаад ирсэн. Тэгэхэд тойрог гэдэг бол ард түмний төлөөлөл. Бундестаг юм уу, одоо жишээ нь, манайхаар бол Улсын Их Хурал ард түмнээсээ тасрахгүйн тулд тойргийн төлөөлөл гэдэг хүн ам зүй тэр нутаг дэвсгэрийн хэмжээ энэ тэрээ харгалзаад

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

энийгээ бас маш сайн бодолцох ёстой парламент бол ард түмнээсээ тасарч болохгүй. Яагаад гэвэл энэ хууль гаргадаг. Тэр хууль тогтоох байгууллага чинь өөрөө улс орныхоо тэр ард иргэдийн эрх ашгийг хангах л хууль гаргадаг болохоос биш өөр нэг захиалгаар ч юм уу хууль гаргадаг байгууллага биш. Тэгэхээр энийгээ ч гэсэн маш сайн манайхан мэдэж ярих хэрэгтэй байна. Тэгээд би энэ дээр одоо жишээ нь 152 биш харин хүн амынхаа тоотой харьцуулахад 120 дотор бол мэдээж гишүүдийн тоог өнөөдөр хүн амынх өсөлттэй уялдаад нутаг дэвсгэрийнхээ энэ нөхцөл байдалтай уялдаад хүн ам гишүүдийн тоог ингэж нэмэх нь бол бас зөв юм болов уу гэсэн байр суурь хувь хүний хувьд би бодож байгаа.

Энд бас манай өнөөдөр эрх барьж байгаа намын хувьд ч гэсэн бас сонгуулийн тогтолцоог улс төрийн намуудын энэ хуулийг цаашид удаан хугацаанд тогтвортой явах сая гишүүдийн ярьж байгаа өмнөх энэ алдаа оноог энэ яагаад Монгол Улс хөгжихгүй байгаад байгаа юм? Яагаад авлигал хээл хахуульд зарим нь автаад байгаа юм? Үнэнийг хэлэхэд сонгосон хүмүүсийн зарим нь яг төрөө төлөөлж чадаж байна. Түмнээ төлөөлж байхад. Өөрийгөө төлөөлөх эсвэл бүлэглэлээ компаниа төлөөлсөн хүмүүс ч гэсэн орж ирчхээд энэ нь өөрөө 30 жилийн Монголын хөгжлийн ингээд гагцхиад байгаагийн тод жишээ шүү дээ.

Тэгээд бид нар өнөөдөр бүүр тэр нийтийн эрх ашгийн хууль Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, Засгийн газрын сайд нар аймаг сумдын Засаг дарга нар төрөөс хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт тендерт оролцохгүй байя гэдэг хууль хүртэл гарахад хүргэж байна шүү дээ. Энэ юу юм гэхээр тэр хэнийг сонгох вэ гэдэг л төлөөлөл. Чадаж байна уу чадахгүй байна уу гэдэг л сонголтын асуудал. Тэрнээс биш тооноос болчихоод байг юм биш. Зарим нэг хүмүүс бол зүгээр тоо л нэмчихвэл бүх юм сайхан болчих гээд байг юм шиг яриад байх юм.

Магадгүй энэ тоо нэмсний дараа, дараагийн сонгууль болохоор дахиад Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулаад үгүй ээ, энэ ёстой замбараагүй болчихлоо энэ тоог хасахгүй болохгүй нь гээд сууж байх магадлал өндөр байна шүү дээ.

Ер нь Сонгуулийн тухай хуулийг ингэж сонгууль болгоны өмнө өөрчлөөд байх буруу. Бусад улс бүх хөгжссөн орнууд ярьж байгаа. Энэ бол тогтвортой байх ёстой гээд.

Тийм учраас бид одоо цаашидаа дахин дахин ингээд богино хугацаанд. 4 жил 4 жилээр өөрчлөөд байхгүйн тулд энэ удаад алсыг харсан урт хугацааны бодлогоо тооцоолсон. Хүн амаа улс орноо хөгжүүлэхийг бодсон тогтвортой хууль гаргахын тулд энэ дээр нухацтай хандах ёстой гэсэн байр суурьтай байна. Тэгээд би Засгийн газраас оруулж ирсэн энэ төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Харин тоо 50, 50 гэдэг дээр арай санал нийлэхгүй байгаа. 60, 40 юм уу 70, 30 гэдэг бол Монгол Улсын өнөөгийн хөгжилд чухал. Тэгээд хэлэлцүүлгийн явцад жишээ нь 60, 40 гэвэл илүү тэр нөгөө ард түмний төлөөллийн байгууллагынхаа тэр үүрэг төлөөллийг бид хангаж чадах ёстой.

Тэрнээс биш намын нэрийн жагсаалтын араас баахан хүн орох хүсэл мөрөөдөлд автчихсан хүмүүс байгаад байна шүү дээ.

Зарим нь бүр бодолдоо уярчхаад яваад байна шүү дээ. Тэгж болохгүй. Парламент тоглоомын байгууллага биш. Ялангуяа Монгол Улс парламентын засаглалтай энэ парламентын ардчилал үнэ цэнээ хамгаалах гэдэг маш чухал. Өнөөдрийн ялангуяа геополитикийн нөхцөл байдал энэ тэрээ харахад.

Тэгэхээр 152 гэдэг тоон дээр Нямбаатар сайдаас асууя.

Ер нь бол нааштай цаашид хандаад хүн ам, энэ нутаг дэвсгэр

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

нэгжсийнхээ нөхцөл байдал энэ тэр гээд ер нь 120 дотроо шийдээд явчих бололцоо байгаа гэдэгтэй та бас санал нийлэх үү гэдэг дээр нэгд хариулт авахыг хүсэж байна. Баярлалаа.

Н.Энхболд: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би төсөл санаачлагчийн байр сууринаас Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын хүрээнд Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмэгдүүлж дэвшилтэт сонгуулийн тогтолцоог нэвтрүүлсэн ийм төслийг өргөн барь гэдэг энэ агуулгаар ажлын хэсэг төслийг боловсруулсан. Одоо тоог энэ хүрээнд тоог хэд байлгах тогтолцоог ямар түвшинд хэдэн хувьтай болговол өнөөдрөөс эхлээд энэ парламентын гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Энэ хэлэлцүүлгийн шатад гишүүдийн олонх нь хэрхэн шийдэж цөөнхийнхөө байр суурийг хэрхэн хүндэлж, энэ төсөл хэлэлцүүлэг цаашаа хэрхэн үргэлжлэх нь парламентын гишүүд, парламентад байгаа улс төрийн намуудын улс төрийн шийдвэрийн эцсийн үр дүнгээр тодорхойлогдох байхаа гэж бодож байна.

Мэдээж хэрэг гишүүн бүр өөр өөрийн гэсэн байр суурьтай байгаа. Манайхан ч бас зарим талдаа эртээд бүлгийн хурал дээр ч гэсэн анзаарагдаж байсан. Тооны бэлгэдлийн асуудал ч хүртэл яригдаж байсан. Тэгээд энэ бол хэлэлцүүлгийн шатанд шийдэгдэж болох асуудал байхаа гэж бодож байна.

Н.Энхболд: Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Өнөөдөр бас эрх барьж байгаа МАН-ын хувьд улс орны урт хугацааны тогтвортой хөгжил, алсын хараа-2050 гээд энэ бүхний үүднээс бас энэ Улсын Их Хуралд цөөнхийн төлөөллийг хангая. Хүн ам сонгогчдын 51-ээс илүү хувьтай байгаа эмэгтэйчүүдийн

төлөөлөл өнөөдөр бага байна. 34 хувийг эзэлж байгаа залуучуудын төлөөлөл бага байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гээд үнэхээр төрийг түмнийхээ төлөө ажиллаж байх төлөөллийг хангахын тулд тогтолцоон дээр тодорхой хэмжээний өөрчлөлт оруулъя гэсэн санаачилга гаргаж байгаа нь өөрөө маш чухал. Түүнээс биш энэ нь тоо юм уу зүгээр л 50, 50 болгохоод энэ нь өөрөө парламент тогтчих. Энэ олон нам нь нэг намын дарангуйлал биш олон нам болчих энэ тэр гэсэн тийм нэг суртал ухуулга шиг юмнууд хэрэггүй болов уу гэж бодож байна. Ийм зүйл ард түмэн ч өөрөө шууд хэлж байна шүү дээ. Бид чинь ард түмнээс сонгогдсон гишүүд иргэдтэйгээ байнга уулзаж байгаа. Иргэд энэ дээр яг хэлж байна шүү дээ. Бүх түвшинд та нар энэ хүн ам бодоод үз. Өнөөдөр нөхцөл байдлаа хар. Улс орны эдийн засгаа хар, хөрөнгө мөнгөө хар, гадаад нөхцөл байдлаа хар.

Тийм учраас 152 гэдэг чинь тоо нь их байна аа. Харин нэмэх гэдэг дээр бол санал нэг байна. Биднийг төлөөлөх төлөөлөл маань бас тэнд төлөөлж чадахуйц чадвартай байх ёстой гэсэн байр сууриуд илэрхийлж байг учраас бид нар бас энэ хэлэлцүүлгийн явцад энэ асуудал дээр маш нухацтай хандах зөв болов уу гэж байр сууриа илэрхийлмээр байна. Баярлалаа.

Н.Энхболд: Санал хэллээ. Доржханд гишүүний микрофоныг өгье.

Т.Доржханд: Баярлалаа. Би асуултаасаа өмнө бас нэг түүхээ бас тодорхой хэлэхгүй бол болохгүй юм шиг байна аа. Яагаад өнөөдөр энэ асуудал хэлэлцэж байгаа юм бэ гэхээр Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол гарсан байдаг юм.

Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолоор тов тодорхой чиглэлийг бол Засгийн газарт өгсөн байгаа. Энэ бол тоо болон тогтолцооны асуудлыг тусгаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

төслийг боловсруулаад Улсын Их Хуралд өргөн мэдүүл ээ гэдэг ийм үүрэг юм. Энэ үүрэг чинь Улсын Их Хурлын чуулган дээр батлагдаж гарсан ийм ажил юм шүү, нэг.

Энэ 54 дүгээр тогтоол чинь яагаад гарчихсан юм бэ гэдгээ дахиад эргээд үзье. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр тогтоол энд байна. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 02 дугаар тогтоол энд байна.

Энэ дээр 01 нь тогтолцооны асуудлаар, 02 нь болохоор гишүүдийн тооны асуудлаар тов тодорхой зөвлөмж гаргаад, тэгээд үүнийгээ Үндсэн хуулийн их суудлын хуралдаанаар эцэслэн шийдвэрлэсэн ийм тогтоол юм.

Яагаад би энэ асуудлыг ярьж байна гэхээр энэ 01, 02 дугаар тогтоолыг гарахад иргэний хувиар мэдээлэл гаргасан юм” Хоёулан дээр нь. Энэ мэдээлэл гаргасны үндсэн дээр шийдвэр гарсан байдаг юм.

Тэгээд Улсын Их Хурал дээр яригдаад тогтоол гарсан байдаг. Энэ бүгд бол процесс нь ингэж явсан юм. Яагаад энэ 01, 02 дээр Тогмидын Доржханд гэдэг хүн, хуульч Үүрцайхын хамт мэдээлэл гаргасан юм бэ гэхээр зарим нь болохоор эх баригчдын хүсэлтээр явсан юм гэдэг. Тийм юм байхгүй.

2016 онд Хүн намын зүгээс яг тоо болон тогтолцооны асуудлаар шаардлага хүргүүлсэн байдаг юм, Цэцэд хандсан байдаг юм. Бүх хэвлэлийн хурлуудаар сүүлийн 7, 8-н жил энэ асуудлыг ярьсан байдаг юм. Ярихдаа бид нар дандаа судалгаан дээр үндэслэж ярьсан байдаг юм. Онол дээр үндэслэж ярьсан байдаг юм.

Цаашидаа парламентын засаглалтай улс байх уу, үгүй юу гэдэг дээр бид нар тов тодорхой байр, суурьтай юм. Энэ намын байр суурь юм, ээ маш олон судлаачдын байр суурь юм. Энэ олон улсын зөвлөгөө өгдөг судлаачдын байр суурь юм. Бид нар одоо судалгаан

дээр үндэслээд шийдвэр гаргадаг байх юм уу? Аль эсвэл хоорондоо яриад сайхан бурхны тоо, сайхан тоо гээд түүн дээрээ ярьж талцаж хуваагддаг байх юм уу?

Энэ Нямбаатар сайдын ярьж байгаа үнэн шүү дээ. 92 онд бүүр бодитойгоор бүх юмыг нь үзсэн юм. Үзээд ярихад бол тэр Чимэд гуай эд нараас оруулж ирсэн тоо чинь болохоор 120 байсан юм байна лээ шүү дээ.

Гэтэл Ардын Их Хурлын депутатууд нь болохоор эдийн засаг ийм муу байхад та нар юу яриад байгаа юм бэ наадхаа 51 болго гэсэн юм байна лээ шүү дээ. Тэгээд л Монголчууд чинь дундажладгаараа 76 гээд л явчихсан. Үүнийхээ хорыг өнөөдөр 30 жил үзэж байгаа нь бодитой шүү.

Яагаад өнөөдөр авлига хээл хахууль ингэж их гараад байгаа юм. Яагаад парламентын энэ гарсан шийдвэрүүд чинь цөөхөн хүний түвшинд шийдэгдээд яваад байгаа юм. Бодитой шүү дээ, Хөгжлийн банкны хулгай, нүүрсний хулгай, бодитой жишээнүүд шүү дээ энэ чинь. Цаашиагаа ямар хулгайнууд байгаа билээ гээд ингээд харах юм бол энэ зовлон чинь дуусахгүй шүү дээ.

Тэгээд энэ чинь ганцхан Монголын түүх биш дэлхийн түүх шүү дээ. Олон улсад би нэг тоо асуугаад байгаа хүмүүс дээр нэг нэмээд нэг санаа хэлчихмээр байгаа юм. Ямар санаа вэ гээд тэгэхлээр тооноосоо хамаарч төлөөлөл тогтдог нь үнэн. Гэхдээ парламентын засаглалтай орнууд чинь бас тодорхой зохимжит парламентын тоо гэж байна. Энэ бол 120-800-гийн хооронд байна. 120-оос доошоо байх юм бол хуйвалдаан үүсдэг, хулгай үүсдэг дэлхийн түүхүүд байна. Монгол яг энэ түүхийг давтаад байгаа нь бодитой. Иргэд бүгд мэдэж байгаа.

2 дугаарт, 800-аас дээш байх юм бол шийдвэр гардаггүй юм байна. Миний бодол зөв, чиний бодол буруу гэсэн байдлаар явсаар энэ чинь хар зах

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

болчихдог. Одоо нэг жишээ хэлье л дээ. Тухайлбал Хятад, Энэтхэгийн жишээ аваад байх шиг байна. Хятад улс 1.4 тэрбум хүнтэй, Энэтхэг 1.3 тэрбум хүнтэй. Гэхдээ Энэтхэгийн 1.3 тэрбум хүнтэй мөртөө парламентын засаглалтай орон. Парламентын гишүүдийн тоо нь хэд юм? 788 байна. 245 нь дээд танхим, 543 доод танхим. Үгүй ээ тэгвэл 1.3 4 тэрбумтай юм бол их л байх ёстой биз дээ? Яагаад 800 дотор байгаад байгаа юм?

Яагаад вэ гэхээр энэ чинь өөрөө онолтой, үзэл баримтлалтай, судалгаатай болохлоор цаашаагаа үр ашиггүй болохлоор ингэж яваад байна шүү дээ. Ийм болохлоор. Гэтэл нөгөө тал чинь Монгол Улс жижигхэн шүү дээ. Хөөрхий муу Хятадын нэг муу хот ч биш дүүргийн түвшинд шүү дээ гээд болно болно. Үгүй ээ тийм юм бол Монгол Улс тэр дүүргийн түвшинд очиж яриа хэлцлээ хий л дээ. Хятадын нэг дүүргийн даргатай Ухнаагийн Хүрэлсүх гэдэг хүн очиж яриа хэлэлцээ хийгээд цуг зогс л доо. Дэлхийд ийм юм байдаггүй юм шүү. Дэлхийд ийм юм байдаггүй юм шүү.

Өнөөдөр Монголоос гадна маш олон жижиг үндэстнүүд байдаг юм. Одоо ингээд нийтдээ 235 улс байна. Монгол Улс нь хүн амынхаа тоогоор 136-д ордог юм. Гэтэл бид нараас доошоогоо цөөхөн хүн амтай 100 улс байгаа. 100 улсын би тухайлбал 20, 30-аар нь очиж ажиллаж байсан эдийн засагч хүн байна. Тувалу гэдэг улс 11 мянган хүнтэй. Өөрийн гэсэн тусгаар улс. Дээрээс нь НҮБ-ын бүртгэлтэй. Палау гэж улс 18 мянган хүнтэй. Трибат 119 мянган хүнтэй. Тэгсэн мөртөө 10 мянган хүнтэй улсын төрийн тэргүүн нь очоод Цагаан ордны өмнө Трамптай юм уу, аль эсвэл Обаматай цуг зогсоод улс орныхоо асуудлыг ярьдаг юм.

Өнөөдөр Хятад улсын Сангийн сайдтай энд Монгол Улсын Сангийн сайд ирээд бодлогоо ингээд нэг түвшинд ингээд ярьдаг юм. Тэнд бол тэр тооны асуудал

хамаагүй байдаг юм. Тэгэхлээр төр бол өөрийн гэсэн хангалттай хилээ манадаг байна уу, цагдаатай байдаг байна уу, татвараа авдаг байна уу ийм функцүүд нь бүх төрд байдаг юм. Энэ тооноосоо хамаардаггүй юм. Ийм болохлоор өөрийнхөө улсыг гадаад түвшинд битгий жижигхэн харагдуул нэг. Битгий өөрсдийгөө Энэтхэг, Хятадуудтай харьцуул. Тэгэх юм бол бид нар тэр нэг дүүргийнх нь түвшинд очиж харьцах болно шүү. Энийгээ манай бас улс төрчид маань бас анхаараарай гэж хүсэж байгаа юм.

Би өнөөдрийг хүртэл 2 дахь удаагаа Монгол Улсынхаа 21 аймгаар Хүн намын залуучуудтай бас тойрсон, ажлын албаныхаа залуучуудтай тойрсон. 21 аймаг, 9 дүүргээр бүгдэнгээр нь явсан. Өмнөх жилтэй харьцуулах юм бол иргэдийн хандлага өөрчлөгдсөн байна. Яагаад вэ гэхлээр Хөгжлийн банкны хулгайг ойлгоогүй байсан юм. Яагаад вэ гэхээр энэ нүүрсний хулгай ил болоогүй байсан юм.

Цаашаа үүнийгээ яаж өөрчлөх юм бэ л гэдэг хүлээлт энийгээ өөрчлөөч ээ л гээд байгаа байхгүй юу. Өөрчлөх хамгийн том олон улсын жишиг нь юу вэ гэхлээр нэг Улсын Их Хурлын гишүүний эрх мэдлийг буулгах, кнопынх нь хүчин чадлыг буулгах энэ л олон улсын түвшин шүү дээ. Тэгээд ийм л байдлаар шийднэ гэсэн иргэд ойлгоод байгаа шүү. Бүгд ойлгогдож байгаа.

Одоо харин асуулт байгаа. Ажлын хэсгээс тэр тоо гэдэг бол нэлээн асуудал гарах юм шиг байна. Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр яагаад 152 юм бэ гэдгийг дахиад нэг асуучихмаар байна. Ялангуяа тэр математикч түрүүн тодорхой яримаар байна шүү. Тэрийг хэлчихмээр байна.

2 дугаарт, нөгөө Үндсэн хууль дээр чинь эдийн засгийн зохицуулалтууд уг нь хэрэгтэй байгаад байгаа юм. Тухайлбал тэр хотуудын боломжийг нээх. Өнөөдөр

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

чинь ингээд цоож зүүчихсэн шүү дээ. Тийм биз? Цаашаа тэр хүний эрхийн асуудлууд байна. Үндсэн хуулийн цэцийг хараат бус байлгах. Цаашаагаа ингээд урт хугацаагаар үйл ажиллагаа явуулдаг тэр боломжийг нь нээх гээд сайн зохицуулалт байсан. Энийгээ одоо бид нар хэзээ ярих юм бэ?

Н.Энхболд: Тооны талаар түрүүн 2 ч хүн их тодорхой ярьсан даа. Тэгэхдээ юу яая даа. Ууганбаатар багш товчхон түрүүчийнхээ юмыг маш товчхон дахиад нэг давтаад хэлчих. Тэгээд 6 номерын микрофон.

Н.Ууганбаатар: Сайн байна уу? Намайг Нинжбатын Ууганбаатар гэдэг. МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн дэд профессор, Математикийн тэнхим болон Америкийн Нэгдсэн Улсын Веллеслей /Wellesley/ коллежийн Математик ба ардчилал гэсэн хүрээлэнгийн гишүүн ийм хүн байгаа юм. Энэ чиглэлээр ер нь бол 10-аад жил математик, ардчиллын хоорондын холбоог судалсан. 10-аад эрдэм шинжилгээний өгүүлэлтэй ийм хүн байна.

Тэгээд 152-ын хувьд бол би түрүүн ерөнхийд нь тайлбарласан. Цаана нь юу байгаа вэ гэхээр зэргийн хууль гэдэг ийм хууль хүчинтэй юм байна гэдгийг нь олж тогтоосон байдаг. 1980-аад оны үед олж тогтоосон ийм зүй тогтол. Тэгээд энэнээс хойш маш олон удаа шалгасан. Маш олон удаа шалгахаар яадаг вэ гэхээр зэргийн хууль нь бол хүчинтэй хэвээрээ л байгаад байдаг. Зөвхөн зэргүүд нь жоохон өөрчлөгдөөд байдаг. 0 4, 033 ч юм уу ингээд юунаасаа хамаараад жоохон өөрчлөгдөөд байдаг.

Тэгээд би хамгийн сүүлийн одоо тэр зэргүүдийг нь үнэлсэн үнэлгээгээ түрүүн танилцуулсан. Дэлхийн дунджаар гэх юм бол 150 гэдэг тоо гарч байгаа. Ардчилал хамгийн сайн байгаа Скандиновын 4, 5 орны 5 улс байгаа Исландыг оруулах юм бол. Тэр жишгээр явна гэвэл 162 гэдэг тоо байгаа.

Ардчиллын хувьд ажиллагаатай ардчилал гэдэг ангилалд ордог. Монгол Улс болохоор алдаатай ардчилал гэдэг ангилалд нь ордог. Ажиллагаатай ардчилал гэдэг ангилалд нь ордог 30-аад орноос хүн амын тоо нь 12 сая дотор байгаа орнууд дээр тэр 24 улс байгаа ихэнх нь жижигхэн улс байгаа гэсэн үг. Тэр нь тэд нарын жишгээр тооцох юм бол 137 гэдэг ийм л тоонууд гарч байгаа юм.

Н.Энхболд: Баярлалаа. Сарангэрэл гишүүн асуултаа асууя.

Д.Сарангэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Үндсэн хууль гэдэг бол төр ард түмэнтэйгээ хийсэн зөвшилцлийн гэрээ. Тийм учраас энийг бол парламент болон парламентад суудалтай намууд дангаараа шийдэх боломжгүй. Энэ асуудалд бид нар маш нухацтай, маш хариуцлагатай хандах ёстой. Би энэ хуулийн төслийг бол Засгийн газар хуулийн дагуу өргөн барьсан. Яагаад гэвэл Улсын Их Хурал өөрийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн төслийг өргөн барих юм бол эрх ашгийн зөрчил гарах учраас Засгийн газар энэ хуулийн төслийг өргөн барьсан гэж ойлгож байгаа.

2 дугаарт, энэ тогтолцооны өөрчлөлт, гишүүдийн тоог нэмэгдүүлэх зэрэг хэд хэдэн одоо ард иргэдийн анхаарлын төвд байгаа асуудлын өөрчлөлтүүдийн төслийг хийхдээ мэргэжлийн судлаачдын гаргасан санал дээр суурилсан гэж ойлгож байгаа юм. Түрүүн Батсуурь гишүүн хэлж байна лээ. Энэ тоон дээр янз бүрийн тайлбарууд байна гэж. Би үүнтэй санал нэг байгаа. Тухайлбал одоо 76 гишүүн хэт цөөн байгаа учраас 1 гишүүний кнопын эрх хүчин чадал өндөр байна.

2 дугаарт, 76 гишүүн худалдагдахад амархан гэж. 152 гишүүн болохоор зэрэг худалдагдахгүй гэдэг баталгаа хаана байна? Нэгдүгээр асуулт.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

2 дугаарт, зөвхөн тооны өөрчлөлт хийгээд, парламент одоо маш шулуун шударга үндэсний аюулгүй байдлыг хангах хэмжээнд очно, бүх асуудлыг шийднэ, бүх зүйл сайн сайхан болно гэхэд итгэл бас төгс биш байна.

Тийм учраас бол энэ тайлбарыг их үндэслэлтэй хиймээр байна. Энэ бол их чухал гэж би бодож байна. Яагаад гэвэл янз бүрийн тайлбарууд хийгээд байгаа. Тийм учраас энэ одоо яагаад 152 болох ёстой вэ гэж. Олон орны тоонуудыг харсан л даа.

Тухайлбал, 5 сая хүн амтай Шинэ Зеланд Улс 120 парламентын гишүүнтэй байна лээ. Тэгээд энэ тоог бид нар их олон удаа ярилаа гээд байна л даа. Гол нь энэ гаргаж байгаа тооны үндэслэлүүдээ үндэсний аюулгүй байдлын түвшинд, ард түмний төлөөллийн хувьд, улс орны дархлааны хувьд, парламентыг бэхжүүлэх тал дээр ямар ач холбогдолтой тоо юм бэ гэдгийг олон түмэндээ маш сайн тайлбарлах ёстой. Иргэдэд ийм ойлголт байхгүй байгаа учраас 76 хулгайчийн тоо 152 болох гэж байна. Өмнөхийнхөө идэж уухыг яая гэж байж 152-ыг бүүр дийлэхээ болино гэдэг ийм л ойлголт нэвт явчихлаа шүү дээ. Батсүрэн гишүүн ээ. Тэгээд би бол эрдэмтэн судлаачид та бүхэн яагаад одоо энэ хуулийн төслийг боловсруулахдаа энэ тоонуудынхаа тайлбар үндэслэлийг сайн гаргаж өгч ийм ойлголт түрүүнд хүртэл одоо ингээд явчхав гэдгийг би гайхаад байгаа учраас та бүхнээс бол би энэ хариултыг нэгдүгээрт хүсэж байгаа юм.

Тэгэхээр одоо бас нэг асуудал байгаад байгаа юм. Ерөөсөө хамгийн гол нь одоо 76 гишүүнтэй Монголын парламент 3.4 сая хүн амтай Монголын ард түмнийг төлөөлж чадаж байна уу, үгүй юү гэдэг энэ асуудал. Гаднаас маш их шүүмжлэлтэй байна. Ийм шүүмжлэл их байгаа нь парламент өөрөө ард түмнээ төлөөлж чадахгүй байгаа юм болов уу гэдэг бас нэг ийм үндэслэл байж болох байх гэж ингэж бодож байгаа юм.

Тийм учраас энэ тайлбаруудаа та бүхний өгсөн энэ мэдээллээс үүдээд сэтгүүлчид асуухаар зэрэг гишүүн болгон өөр өөрийнхөө өнцгөөс өөр өөрийнхөө өнгөөр та бүхний өгсөн мэдээллээр тайлбарлаад байгаа юм.

Яах вэ, нэг зүйл жосоохон үндэслэлээс сонсогдож байгаа юм. 76 гишүүн бол тухайн үедээ 27 мянган хүнийг төлөөлж байсан бол одоо 3.4 сая хүн амтай болсон үед 1 гишүүн 45 мянган хүнийг төлөөлөөд ард иргэддээ хүрч, очиж ажиллаж чадахгүй байна гэдэг бас нэг зүйл яриад байгаа юм.

Хамгийн гол миний хэлэх гэж байгаа зүйл бол 76 бай, 152 бай, хэд ч бай нэр дэвшилт дээр гол асуудал байна гэж ингэж үзэж байгаа юм. Өнөөдөр тухайлбал, нүүрсний хулгай, концесс, тендер, төмөр зам, ЖДҮ есөн шид нь бүрдчихлээ шүү дээ. Тийм ээ? Үгүй ээ энэ чинь нэг цөөхөн хүний л асуудал л даа. Энд бас огт оролцоогүй хүмүүс байна. Тэр бүгдээрээ бол оролцсон гэдэг ийм ойлголтыг ард түмэн нэгэнтээ авчихсан. Яаж ч өөрийгөө хамгаалах гээд, цэвэрлэх гээд нэмэргүй болчихсон.

Тэгэхээр нэр дэвшилт дээрээ бас давхар анхаарах ёстой гэдгийг зөвхөн энэ Улсын Их Хурлын гишүүдийн тоог нэмчихээр зэрэг хулгайчгүй болоод парламент дархлаатай болоод бүх асуудал шийдэгдэх юм шиг тийм тайлбар чинь явахгүй байна.

Тийм учраас давхар өөр саяын энэ миний ярьсан энэ хүчин зүйлүүд энэ сөрөг үзэгдлүүдийг хаахын тулд яах ёстой вэ? Энэ 152 чинь энийг хааж чадаж байгаа юм уу, үгүй юм уу? Энэ асуудлыг л одоо манай эрдэмтэн, судлаачид үндэслэлтэй тайлбарлаад, тэр яриад байгаа олон дэлхийн сонгодог жишгүүдийгээ бидэнд тайлбарлах шаардлагатай байна л даа. Үүнээс түрүүний одоо яагаад 152 вэ гэхээр зэрэг хариулж байгаа хоёр, гуравхан, хоёр талаас нь тайлбарлаж байгаа тэр тайлбар чинь хангалтгүй байна гэж би үз. Тийм учраас та бүхэн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

маань хариултаа өгөөрэй. Дараа нь би тодруулгаа хийе. Баярлалаа.

Н.Энхболд: Нямбаатар сайд эхлээд хариулсан нь зөв байх. Улс төрийн өнцгөөс нь тайлбарлах хэрэгтэй болох байх. Тэр баталгаанууд хаа байна гэж байна. Эрдэмтэд бол одоо цэвэр шинжлэх ухаан талаас нь л мөрдөгдөж байгаа онол талаас нь яасан байх. Нэг их улс төрөөр тэд нар нэг их хараад явж байгаа болов уу даа яаж байгаа бол? Цэвэр одоо шинжлэх ухаан талаас нь л тайлбарлаж байгаа болов уу гэж бодож байна.

Нямбаатар сайд эхлээд хариулъя. Дараа нь нэмэх юм байвал Ууганбаяр нар бэлдэж байгаарай. Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Баярлалаа. Тооны хувьд Сарангэрэл гишүүн сая хэллээ. Тухайн үеийн нөхцөл байдал, мөн 1992 оны шинэ Үндсэн хуулийг хэлэлцэж байх үед хуулийн төслийн эрх баригч Бираагийн Чимэд гуай анх 120 гишүүний тоотойгоор парламентын гишүүний тоог анх төсөлд оруулж ирсэн. Тухайн үед хэлэлцүүлэг зохион байгуулахад оролцож байсан Ардын Их Хурлын гишүүд 51 болгож одоо гишүүдийн тоог багасгая. Эдийн засаг хүнд үед олон одоо парламентын гишүүдтэй байх нь зохимжгүй ёс суртахуун талаасаа гэдэг ийм олон хэлэлцүүлгүүдийн үр дүнд, дунд нь зөвшилцлийн үр дүнд өнөөгийн 76 гэдэг тоо гарч ирсэн гэдгийг бас Доржханд гишүүн ч гэсэн Үндсэн хуулийн эх сурвалжаас одоо эш татаж хэлж байх шиг байна.

Бид нар өнөөдөр нэгдүгээрт хүн амын тоо их болсон.

2 дугаарт, парламентад 1 хүний, 1 гишүүний эрх мэдлийн жинг бууруулах ийм шаардлагууд бий болсон. Энэ утгаараа тоог нэмэгдүүлж байгаа. Та ч дурдлаа. 23 мянган хүн төлөөлж байсан бол өнөөдөр 45 мянган хүнийг төлөөлж байна гэдэг бол их том ялгаа гарсан.

Дээр нь өнөөдөр манай парламентын ачаалал яг одоо бид нарт өөрсөд дээр маань тохиолдож байгаа хамгийн том асуудал бол манай парламентын гишүүд ерөөсөө 2-3 Байнгын хороонд харьяалагдаж байгаа. 2-3 Байнгын хороонд харьяалагдаж байгаа энэ өнөөдрийн харилцаа маань хуулийг хэдий хэр чанартай хэлэлцэх вэ, парламентаас гарч байгаа шийдвэрүүдийн төсөл дээр Байнгын хороо болгон дээрээ Байнгын хорооны гишүүд яг адилхан сууж, шийдвэр гаргалтыг нь тэр болгон саналуудаа тусгаж чадаж байна уу, үгүй юү гэдэг асуултын том тэмдэг үлдчихээд байгаа юм.

Бид нартай одоо хамгийн ойр жишээ татаж болохуйц улс бол Бүгд Найрамдах Солонгос Улсын парламент байгаа. Энэ парламент ерөөсөө 20 Байнгын хороотой. 1 Байнгын хороонд 20 орчим гишүүд харьяалагддаг. 1 гишүүн 1 л Байнгын хороонд харьяалагддаг. Хуулийн тухайн Байнгын хороогоор харьяалагддаг хэлэлцүүлэг зөвхөн 1, 2 дугаар хэлэлцүүлэг тухайн Байнгын хороон дээрээ хэлэлцүүлэг нь болж дуусдаг. Эцэст нь Хуулийн байнгын хороогоор орж хянагдаад тэгээд чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хууль эцэслэн батлагддаг. Ийм л дэгтэй байгаа.

Гэтэл бид бол өнөөдөр хамгийн супер, универсал ийм түвшиндээ парламентын гишүүд 3 Байнгын хороонд жишээ нь харьяалагдаж байх жишээтэй.

Юун дээр энэ парламентын гишүүдийн тоог нэмэгдүүлж байгаагийн цаад улс төрийн ач холбогдлын талаар зүгээр бид ажлын хэсэг дээр ярьсан зүйл бол нэгдүгээрт энэ санал гээгдэхээ больчих юм. Одоо холимог тогтолцоо руу шилжээд ирэхээр.

2000 онд манай нам 72 суудал авсан. Нийт сонгогчдын 51 орчим хувийн саналыг аваад парламентын 76-72 хувийн тийм, 72 суудлыг 2000 онд авч байсан. Тэгэхээр энэ цаана нь юуг хэлж байна вэ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

гэвэл нийт сонгогчдын бараг 40 гаруй хувийнх нь санал үндсэндээ гээгддэг энэ тогтолцоо бол мажоритар тогтолцоо юм. Ийм учраас санал гээгддэггүй тогтолцоо руу явъя гэсэн энэ зүйлийг ярьж байгаа.

Дээр нь энэ мажоритар тогтолцооны нэг сул тал нь улс төрийн намуудын төлөвшилт их алдаатай байгаа. Өнөөдөр 2 нам энэ 31 жилийн хугацаанд 31 жилийн хугацаанд 2 нам засгийн эрхийг барьсан байгаа. Өөр гуравдагч улс төрийн нам эвслүүдээс одоо 2012 оны сонгуулийн үр дүнгээр Монгол Ардын Хувьсгалт нам одоо эвсэл болж, бүлэг болсныг эс тооцох юм бол энэ 31 жилийн хугацаанд өөр гуравдагч хүчнээс бүлэг болж улс төрийн намын төлөвшил бий болж байсан ийм одоо бас тохиолдлууд гарч ирээгүй байгаа.

Баялгийн тэгш бус хуваарилалт явагдах ийм эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл одоо бид нар энэ сүүлийн үед улс төрийн акциуд янз бүрийн байдлаар хийгддэг. Нам дамнасан улс төрийн бүлэглэлүүд үүслээ, баялгийн тэгш бус хуваарилалтыг бий болгож байна гэх мэт. Энэ асуудлуудаас ангижрах зүйл бол улс төрийн парламент дахь гишүүдийнхээ тоог нэмэгдүүлж, сонгуулийнхаа холимог тогтолцоо руу шилжсэнээр илүү их парламентын хяналт, тэнцэл гэдэг юм илүү их бий болох магадлалтай.

Одоо бид нарын өнөөдрийн өргөн барьсан төслөөр тооцож үзэхэд хэрэв энэ гишүүдийн тоо нэмэгдсэн тохиолдолд хамгийн багадаа 4-өөс доошгүй, 5-аас доошгүй намын бүлгүүд үүсэх магадлалтай байгаа юм. Намын бүлгүүд үүснэ гэдэг маань шийдвэр гаргалтад төдий чинээ хяналт тэнцэл бий болох. Эргээд парламент дахь цөөнхийн хяналт гэдэг зүйл бол хамгийн дээд түвшиндээ орж ирнэ л гэж.

Та бүхэн санаж байгаа бол 8 онд бие даагчийн төлөөллүүд орж ирж байсан. 4 онд бас цөөхөн төлөөлөл орж

ирж байсан. 12 онд төлөөлөл орж ирж байсан. 16 онд чинь төлөөлөл бас орж ирж байсан. 20 онд Хөдөлмөрийн Үндэсний намаас гишүүн сонгогдоод ингээд гуравдагч хүчний орон зай бүлэг байгуулах түвшинд бас гарч ирж чадахгүй байгаа. Тийм ХҮН нам. Тийм ХҮН намаас орж ирж байгаа юм.

Тэгэхээр ийм одоо улс төрийн нөхцөл байдал, хүчин зүйлүүдийн үндсэн дээр өнөөдөр тоо тогтолцоо гэдэг зүйлийг оруулж ирсэн ажлын хэсэг дээр энэ талаасаа ч бид нар бас нэлээдгүй ярилцсан гэдгийг хэлье.

Тэгээд би дахиад нэг зүйл хэлье. Энэ бол 2019 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үргэлжлэл юм. Тэр үед Ерөнхийлөгчийн институцээс яг өнөөдрийн энэ одоо гишүүдийн тоог нэмэгдүүлэх 50, 50 хувийн пропорциональ тогтолцоо, мажоритар тогтолцоогоор сонгуулийн тогтолцоог бий болгоё гэдэг санал орж ирээд зөвшилцөл яг дуусдагийн даваан дээр манай намын бүлэг дотор үл ойлголцол үүсээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн ажилд бүрэн төгс явагдаж чадаагүй.

Тэгээд өнөөдөр тухайн үед 19 онд хийгдсэн бол бид нар бас өнөөдөр энэ олон асуудлуудаа шийдчих энэ боломжууд байсан. Би түрүүн нэг жишээ авч хэлсэн шүү дээ Сарангэрэл гишүүн ээ. Бид нар энэ сүүлийн 30 гаран жилийн хугацаанд 76 хуваадаг төсвийн хуваарилалтаар явж ирсэн. Гишүүн болгон улсын төсвийг батлах үед тойрогтоо юу батлуулах вэ гэдгээс шалтгаалж төсвийг батлах кноп дардаг байсан. Тэрнээс биш том төслийг яаж явуулж, тойргийнхоо хөрөнгө оруулалтыг хэрхэн тэвчих вэ гэдэг нэг ч ийм жилийн төсөв үндсэндээ батлагдаж байгаагүй. Энэ бол юу үнэн бодит үнэн.

Үүний үр дүнд бид нар эрчим хүчний асуудал хүндэрлээ. Магадгүй энэ бид огцом шийдвэр гаргахгүй бол 25 он гэхэд бид нар эрчим хүчний том одоо проблемтой бид нар нүүр тулна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Боомтын асуудал юу болчихоод байгаа билээ. Бид нар боомтын сэргэлт гэдэг зүйлээр томруулдаг шилээр сая харж үзлээ. Бид нар 37 боомттой хэр нь 2-хон боомтоо л төмөр зам, авто замаар боомт холбосон. Бусад боомтуудаа юугаар ч холбоогүй л байж байгаа. Бид өөрсдөө уул уурхайн бүтээгдэхүүнээ айлд зарж борлуулдаг л ийм эдийн засагтай улс.

Гэтэл тэр уул уур тодорхой бүтээгдэхүүн зөвхөн боомтоор дамжиж л гардаг. Гэтэл бид нар тэр орлого олдог саваа томруулах хүртэл энэ том бодлогыг өнгөрсөн 30 жилийн хугацаанд төдийлөн хэрэгжүүлээгүй нь энэ мажоритар тогтолцооны бас хамгийн том сул тал юм болов уу гэж бид дүгнэж байгаа.

Н.Энхболд: Сарангэрэл гишүүн тодруулъя, 2 минут.

Д.Сарангэрэл: Би хувь гишүүнийхээ хувьд Нямбаатар сайд аа өөрийн чинь хэлж байгаа тайлбаруудыг бол хүлээн зөвшөөрч байгаа, ойлгож байгаа. Дахин хэлэхэд Монгол Улсын Үндсэн хууль гэдэг бол Монголын төр Монголын ард түмэнтэй байгуулсан зөвшилцлийн гэрээ.

Тийм учраас энэ гэрээг өнөөдөр ард түмний ойлголт, тэр дундаа гишүүдийн тоог 152 хүргэхэд нэлээн шүүмжлэлтэй хандаж байгаа учраас энийг ойлголцолд хүрэхгүйгээр одоо хүчээр хийж болохгүй гэж ингэж үзэж байгаа.

Мэдээж хэрэг одоо нийгэмд янз бүрийн ашиг сонирхлын бүлгүүд үүссэн. Тэр ч бүү хэл улс төрд ч тийм бүлгүүд байгаа тухай бид хоорондоо ярьдаг. Дээр нь өөрийн чинь хэлж байгаа тайлбарууд гээд энэ тогтолцооны өөрчлөлт хийх, гишүүдийн тоог нэмэх, парламентаа бэхжүүлэх, үндэснийхээ дархлааг бас хамгаалах гээд олон зүйлүүд байгааг би ойлгож байгаа.

Тэгэхдээ ард түмэн 4 жил 1 удаа төрийн эрх барьдаг тэр бай эрх барихтай холбоотой энэ асуудлыг ард түмэнтэйгээ ойлголцож, зөвшилцөж бүгдээрэнг нь нэг шийдэлд хүрч байж бид нар энэ асуудлыг хийх ёстой. Яг одоогийн ийм ойлголцлын түвшинд бол би 152 гишүүн болгох саналыг бол дэмжихгүй.

Н.Энхболд: Санал хэллээ. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр өнгөрсөн 7 сарын 15-наас хойш би Ховд аймагт 60 гаруй уулзалт, багаар яваад энэ тэрээ уулзалт хийгээд 60 орчим уулзалт. Дээрээс нь бусад аймгийн, 5 аймгийн томоохон сум дээр явж уулзалт хийсэн. Тэгээд энэ уулзалт дээр ярьж байхдаа би нэг л зүйлийг ярьж байсныгаа дахиад давтаад хэлчихье.

Тэгэхээр гишүүдийн тоог тодорхой хэмжээгээр нэмэхийг дэмждэг гэж, дэмждэг. Тэгэхээр 1992 оны анхны ардчилсан сонгуулиар нийтдээ 900 мянган сонгогчтой байсан юм байна. Тэгээд 76 гишүүн 1 гишүүн нь 12 мянган сонгогчийг төлөөлдөг байж.

Гэтэл өнөөдөр 2 сая 200 мянган сонгогчтой болж байгаа. Тэгээд энэ энэ нь бол одоо 29 мянган сонгогчийг 1 Их Хурлын гишүүн төлөөлөх ийм нөхцөл байдалтай байна. Тэгэх дээр энэ сонгогчдын төлөөлөл муудах эрсдэл бас гарч ирж байна. Тэгэхдээ хөдөө орон нутгаас сонгогдсон Их Хурлын гишүүд бол аймаг, сумд багуудаар яваад, иргэдтэй уулзалт хийгээд, тэдний үгийг төрд дамжуулах тэр ажлаа бол бүрэн дүүрэн хийгээд, зарим гишүүд нь, зарим нь бол хаягчаад явчихдаг. Гишүүд нь хийгээд явж байгаа гэдгээ хэлье.

Тэгэхдээ энэ сонгогчдын төлөөлөл хамгийн их муудаж байгаа тэр хэсэг бол Улаанбаатар хотод Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэг мэтийн 400 мянган хүнтэй тэр дүүрэг дээр зүгээр юу нь ч мэдэгдэхгүй зүгээр тэр Нямбаатар бол

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

жишээ нь одоо тэнд очиж бараг уулзалт хийлээ ч гэсэн тэгээд хүн бүгдэд хүрч чадахгүй ийм л нөхцөл байдалд байж байгаа

Тийм учраас энэ Улаанбаатар хот дахь сонгогчдын төлөөллийг сайжруулах үүднээс цөөн тооны одоо гишүүдийг улс орон даяар бас ингээд нэмэх боломжтой. Тэгэхдээ тэр нь 100-аас дээш гарч болохгүй. 2 оронтой тооноос дээш гарч болохгүй гэдэг ийм байр суурин дээр л би одоо өнгөрсөн хугацаанд ярьсан.

Намын пропорциональ тогтолцооны хувьд бол энэ мажоритар систем бол сонгогчдын саналыг маш их гээдэг ийм одоо тогтолцоо. Өөрөөр хэлбэл 2020 оны сонгуулиар Монгол Ардын нам нийт сонгогчдын 42 хувийн санал авчхаад Улсын Их Хурлын суудлын 82 хувийн суудлыг нь авчгаж байгаа юм. Энэ бол тэгээд 34 хувийн санал авсан Ардчилсан нам болох дээр. Дөнгөж 11-хэн суудалтай ийм байж байгаа.

Тэгэхээр энэ бол одоо сонгогчдын саналыг гээдэг ийм систем учраас энэ одоо мажоритар тогтолцоог болиулж, пропорциональ тогтолцоог Үндсэн хуульд суулгах нь бол зөв л гэж би ингэж ярьж явсан. Тэгэхээр энэ байр суурин дээрээ дахиад байна гэдгийг бас нэгдүгээрт хэлье.

2 дугаарт нь, шүүмжлэлтэй зүйлүүд байна. 3 жилийн дотор хэт олонх болсон эрх баригч нар 3 удаа энэ төр улсын баталгаа болсон, тусгаар тогтнолын баталгаа болсон Үндсэн хуульд 3 удаа гар хүрч байна. Тэгээд энэ 3 удаа гар хүрэхдээ дандаа эрх мэдлийг өөрсдөдөө авч байна.

19 оны Үндсэн хуулийн өөрчлөлт бол нэлээн олон эрх мэдлүүдийг өөр дээрээ авсан. Тэн дотор зассан юмнууд бас их зөндөө байгаа. Түүнийг бас тодотгож хэлэх нь зүйтэй. Тэгээд сая энэ шинэ парламент одоо энэ Үндсэн хуулийн

өөрчлөлтийг хийж, энэ өөрсдөөрөө эрх мэдэл авахыг бол гаргуун хийж байна.

22 оны 8 дугаар сард хийсэн Үндсэн хуулийн өөрчлөлтөөр давхар дээлийг өөртөө авсан. Давхар дээлтэй сайд нар одоо өнөөдөр энэ Улсын Их Хурлын үйл ажиллагааг доголдуулаад байж байгаа шүү дээ. Тэгээд өөрсдөө эрх мэдэл авах болохоор л ерөөсөө энэ Үндсэн хууль руу халддаг энэ байдлаа хэзээ зогсоох юм?

Одоогийн энэ өөрчлөлтөөр 152 гишүүнтэй болох юм байна л даа. 152 гишүүн гэдэг бол жишээ нь хэрвээ пропорциональ нь одоо энэ сонгуулийн хуулиар шийдэгдэхгүй бол Говь-Алтай аймагт 2 мандаттай байсан бол 4 мандаттай болоод нөгөө 2 нөхөр нь одоо сонгохгүй гээд байж байсан 2 нөхрийг нь тэгээд 4 болчихлоор тэр нөгөө хэд дотор жигвээд ороод ирэх нь байна шүү дээ. Ийм боломжийг л өөрсдөө өгч байна шүү дээ.

Тийм учраас энэ ард түмэн бол дургүйцэж байгаа. Өөрөөр хэлбэл 152-ыг бол маш их эсэргүүцэж байгаа. Ийм замбараагүй 100 ямаанд 60 ухна гэж энэ чинь ард түмний дотроос гарсан үг чинь бас учиртай шүү дээ.

2 дугаарт нь, жагсаалт байна. Энэ жагсаалтын ард намаа санхүүжүүлдэг тэр нөхөд бүгдээрээ ингээд ороод ирэх ийм боломжийг бүрдүүлж байгаа юм. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийж байгаа энэ өөрчлөлтийн ар болгон дээр яаж засаглах вэ гэдэг л тактикаар явж байдаг.

2019 оны сонгуулиар танай намын нэг хэсэг хүмүүс энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг тогтолцоо дээр хаяж гарсан нь танай судалгаатай холбоотой шүү дээ. Өөрөөр хэлбэл Монгол Ардын нам үнэмлэхүй ялгах боломж нь энэ одоо мажоритар тогтолцоогоор байна л гэж үзсэн.

Тийм учраас нэг хэсэг хүн чинь хаяж хаяж гарсан байхгүй юу. Өөрөөр

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хэлбэл Хүрэлсүх гэдэг хүний өндөр рейтинг, Эрдэнээ гэдэг хүний нам рейтинг 2-ын хооронд ялалт байгуулах юм байна л гэж үзээд энэ пропорциональ тогтолцоог оруулж ирэлгүйгээр хаяад л гараад явсан шүү дээ. Тэгээд өнөөдөр яаж байна гэхээр дахиж засагдахыг л хүсээж байгаа. ЖДҮ, концесс, Хөгжлийн банк, нүүрсний хулгай, төмөр замын хулгай, энэ бүх хулгайд оролцсон дарга нар бүгдээрээ энэ жагсаалтын ард орж ирэхийн төлөө л зүтгээж байгаа шүү дээ.

Өнөөдөр яаж байна гэхээр дахиж засаглахыг л хүсээж байгаа. ЖДҮ, концесс, Хөгжлийн банк, нүүрсний хулгай, төмөр замын хулгай, энэ бүх хулгайд оролцсон дарга нар бүгдээрээ энэ жагсаалтын ард орж ирэхийн төлөө л зүтгээж байгаа шүү дээ.

Тийм ч учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг хийж, өөрөөр хэлбэл энэ МАН-ын өнгөрсөн 7 жилийн хугацаанд 1 ширхэг ч бүтээн байгуулалтыг хийхгүйгээр яаж уран донгодож, засаглаж болдгийг өнөөдөр харж байна. Энэ бүх зүйлийг нь ард түмэн мэдэж байна. Хүмүүсийн амьдрал хэцүүдэж байна, бараа, бүтээгдэхүүний үнэ өдрөөс өдөрт өсөж байна. Цалин тэтгэвэр тэндээ хүрэхгүй байна. Тэгээд компани, ААН-үүдийн үйл ажиллагаа доголдож байна. Татварын өрөнд бүгдээрээ орж байна. Дээрээс нь компани, ААН-үүдийн нэр хүндэд санаатайгаар эрх баригчид нөлөөлж байна. Ийм нөхцөл байдал дээр ард түмэн дотор унасан нэр хүндийгээ буцааж аврахын тулд сонгуулийн системийг өөрчлөх замаар дахин засаглах тэр зүйлийг л хийж байгаа шүү дээ.

Энд нь АН хавсай байдлаар оролцож байна. 1992 онд энэ Монгол Улс олон намын тогтолцоотой болсон. Харамсалтай нь 2016 оноос хойш манай нам энэ МАН-ын дагуул пасаал маягийн удирдлагуудтай байсны үр дүнд өнөөдрийн ийм арчаагүй байдал бий болж байгаа юм. 200 мянган гишүүдээсээ

асуудлаа шийдээд явах ёстой нам маань өнөөдөр дандаа МАН-тай удирдлагууд маань очиж тохиролцож асуудлаа шийддэг ийм нам болж хувирсан учраас өнөөдөр энэ Үндсэн хуулийн өөрчлөлт, МАН-ын хүссэнээр орж ирж байна.

Н.Энхболд: Пүрэвдорж гишүүн үг хэллээ. 2 минутыг нь нэмээд өгчихье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр сөрөг хүчин бол ард түмэнтэйгээ ойрхон дуу хоолойтой байх ёстой юм аа. Хэт олонх болсон эрх баригчидтай хамтарч, гишүүдийнхээ эсрэг, ард түмнийхээ эсрэг энэ зүйлийг хийх нь буруу юм л гэж би хэлээд байгаа юм. Мэдээж одоо юу байдаг юм, 2 том улс төрийн намын хувьд ярилцах зүйл байдаг л байх, арай хэтрээд байгаа юм биш үү. Энэ хэтрэл чинь биднийг ямар үр дүнд аваачих юм. Тийм учраас энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр би бол хамгийн нүүр баатар энэ 76 гишүүнээс хамгийн нүүр баатраар тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр очиж ард иргэдтэй уулзана гэж бодож байгаа. Яагаад гэвэл өнгөрсөн хугацаанд байсан байр суурь дээрээ, сөрөг хүчнийхээ хийх ёстой тэр үүргийг хэрэгжүүлсэн тэр үр дүн дээрээ би хангалттай очно оо.

Өнөөдрийн МАН-ынхан очвол та нар Монголын ард түмэн энэ хэт их тоо нэмж, өөрсдөө түүн дотроо сэмхэн орж ирэх тэр боломжийг гаргаж байгаа энэ зүйл дээр нь хатуухан хариу бариарай гэж уриалъя.

Н.Энхболд: Үг хэлж, уриалга гаргалаа. Баярлалаа.

Гишүүд хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулаад асуулт тавьж, хариулт авч дууслаа.

Одоо үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байвал нэрээ өгье. Доржханд гишүүнээр тасаллаа.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Үг хэлэх хугацаа 1 гишүүн 10 минут. 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8. 80 минут байна. Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Миний үг хэлэх эрхийг та бүхэн заахгүй ээ. Ард түмний төлөөлөгч гэдгээ ойлгох хэрэгтэй байгаа юм. Үндсэн хуулиар ЗГ, нам, УИХ-д байгаа энэ улсуудаас хамаарахгүй. Монголын түүхэнд бол энэ Үндсэн хууль гэдэг бол судар бичиг нь. Дараагийн 4 жил, 8 жилийн дараа энэ хүмүүс унишина. Хэн юу хэлэв. Ард түмнийг төлөөлж суусан хүн маань учир байдлаа ойлгож уу, ойлгоогүй юу гэж. Одоо ч гэсэн манай сонгогчид маань Сүхбаатар ямар бодолтой байна. Би ЗГ-ын гишүүн учраас өнгөрсөн хугацаанд нэг ч дуугараагүй, байр сууриа илэрхийлээгүй.

13 жилийн өмнө 99 гишүүнтэй байх тухай асуудал ярьсан гэдгээ л тайлбарлаж хэлж байгаа юм. Одоо бол ямар зүйлийг би хэлэх гэж байна вэ гэхээр дараагийн хүмүүс маань зөв зүйтэй ойлгоосой гэдэг утгаар. Сая Пүрэвдорж гишүүн хэлж байна л даа. Ард түмэн, ард түмнийг, ард түмэн засаглаж чадах уу гэдэг асуудлыг эргээд тавих ёстой байхгүй юу, нам засаглаж чадах уу гэдэг асуудал чинь бас адилхан юм байгаа юм. Пүрэвдорж гишүүн. Одоо бид нар энэ өнгөрсөн хугацаанд өнгөрсөн 2 парламентаар ямар асуудал яригддаг вэ гэхээр эрх барьж байгаа МАН харин өмнө нь Үндсэн хуулийн өөрчлөлт хийхдээ анх удаа өөрийнхөө эрх мэдлийг хассан байхгүй юу. Их Хурлын гишүүд төсвийн асуудлыг дангаараа шийдвэрлэхгүй ээ. ЗГ-ын оруулж ирсэн тэр хүрээ хязгаар дотор асуудлаа ярина гэж ингэж шийдвэрлэсэн.

2 дахь нь, Их Хурлын гишүүд сайд нарын томилгоо хийдэг эрхийг хязгаарласан. Урьд нь хэдэн Их Хурлын гишүүн нийлж байгаад энэ 76 дотроос сайдаа томилоод байдаг байсан. Нөлөө үзүүлдэг байсан, огцруулаад байдаг байсан, үүнийг болиулсан. Одоо бид юу ярьж байна вэ гэхээр хэлж байна шүү дээ. Нэг гишүүн асуудал шийддэг 76 хүрээнд

байдаг асуудлуудыг арай өргөн бүрэлдэхүүнтэй болгоё. Аль нэгэн нам ялаад Засгийн газраа байгуулаад ялах нь чухал биш юм байна аа. Гарч ирсэн нам нь бодлого хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн тулд, ард түмнээрээ хүлээн зөвшөөрөгдүүлэхийн тулд, парламент нь илүү олон өнгө солонготой ард түмний ашиг сонирхлын бүлгүүдийг бас багтаасан байж гэмээнэ энэ нам чинь бас улс орноо засаглаад аваад явахад төр нь засаглах чадамж нь, хууль ёсны хүлээн зөвшөөрөгдөх байдал нь сайжрах юм байна аа. Одоо хүмүүс хүлээн зөвшөөрөхгүй байна гэдэг чинь Пүрэвдорж гишүүн ганцхан Ховдыг гуравхан хүн гарч ирээд төлөөлж байна гэж ярьж байна шүү дээ. Гэтэл Ховдыг төлөөлөөгүй байхгүй юу. Ард түмнийг төлөөлөх үүрэгтэй улсууд аймаг, дүүрэг, төлөөлөгч төлөөлдөг юм шигээр ингэж ярьдаг болчихоод байгаа юм. Биднийг Үндсэн хуульд заахдаа ард түмний элч буюу ард түмний төлөөлөгч гэж заасан байхгүй юу. Манай Үндсэн хуульд нэг дутуу чанар байдаг юм. Дандаа төрийн эрх дээд байгууллага, тэгээд Их Хурлын гишүүн эд нар гээд. Төр, ард түмний холбоо холдчихоод байна гэдэг чинь үнэн байхгүй юу. Тэгэхээр ойртуулахын тулд яах юм бэ гэхээр ард түмний төлөөлөгчдийн тоо хэдий чинээ олон болсноороо эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлж байгаа тэр асуудалд олон түмний оролцоо, тусгал, санаа бодол тусгах юм л гэдэг асуудал байгаа.

152 гэдэг бол магадгүй 28 оноос хойших шинэ үеийн шинэ Үндсэн хуулийг батлах үед энэ тоо угаасаа яригдаад энэ ерөөсөө буруу биш л дээ, судлаачид гаргаж тавьж байгаа. Монгол Улсын хүн ам 4 саяд хүрнэ, 5 саяд хүрнэ, энэ 152 дээр хүрэх нь гарцаагүй. Өнөөдөр зүгээр нийгэм, эдийн засгийн байдал, сэтгэл зүйн байдал, улс төрийн орчинтой холбоотойгоор энэ асуудал дээр хүнд сонсогдож байж магадгүй. Гэхдээ өнөөдрийн оруулж ирж байгаа ЗГ-ын төслийн 152 бол буруу биш нь бол үнэн. Одоо шийдэхэд ямар наанатай цаанатай,

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хүндрэлтэй, зовлонтой асуудал байна вэ гэдгийг чинь бид хэлэлцүүлгээр хийх хэлэлцүүлгийг л эхлүүлж байгаа юм. Хувьдаа би хэлж байна шүү дээ. Өмнө нь би 99 гишүүнтэй асуудлыг дэмждэг байсан 13 жилийн өмнө, өөрөө анх гаргаж тавьсан юм аа. Одоо бол засаглах чадамжтай, ард түмнийг төлөөлдөг гарч ирсэн нам нь хүлээн зөвшөөрөгддөг, сөрөг хүчин нь нэг сөрөг хүчин шиг байдаг, гарч ирсэн нам нь нэг нүүр бардам байдаг, парламент дээрээ тэр хэрүүл уруул нь болдог, хүсвэл зарим нь гар зөрүүлдэг л байх ёстой л байхгүй юу. Түүнээс парламентын гадна эсэргүүцэл шүүмжлэл явдаггүй байх ардчилсан төрийн механизм чинь юу юм гэхээр олон түмний ард түмний парламент байж байж л тэр парламент дээрээ учир зүйгээ олдог, зөрчилддөг, зөвлөлддөг, тэгээд шийдвэр гардаг, гарсан шийдвэр нь хүмүүсээр хүлээн зөвшөөрөгддөг байдаг. Үүнийг л бид бий болгочих. Тэгэхээр системтэй явж байна шүү дээ.

Өмнөх ойр ойрхон Үндсэн хуульд гар хүрээд байна гэдэг шүүмжлэлийг би ерөөсөө буруутгахгүй байгаа юм. Тэр хүмүүсийн зөв. Үндсэн хуулийн эрх зүйн зарчмаар ч тэгдэг. Гэхдээ манай парламентад байгаа гишүүд хэтэрхий их эрх мэдэл эдлээд байгаа учраас хязгааргүй эрх мэдэл хүнийг хязгааргүй эвддэг гэдэг. Тэр Актон гээд тэр Британийн тэр хуульчийн хэлсэн үг байдаг байхгүй юу. Хязгааргүй эрх мэдэл хязгааргүй эвддэг юм. Тийм учраас парламент тэр өнгөрсөн 30 жил юу яригдсан юм гэхээр Их Хурлын гишүүн бүгдийг шийдээд байна, бүгдийг шийдээд байна. Тэгэхээр учир зүйтэй сайн засаг гэдэг эрх мэдлээ өөрөө хязгаарладаг засгийг хэлдэг гээд эрх мэдлээ тайрч хязгаарлахдаа зүгээр тайраад хаячхаж байгаа юм биш. Эрх мэдлийг зохистой хуваарилах замаар дотоод хяналт тэнцлийг бий болгож байгаа юм. Үүнийг төрийн ухаан, төрийн удирдлагын онол гэж ярьдаг. Харагдаж байгаа бид байдлаараа хараад байж болохгүй шүү дээ.

Тоог ихэсгэж багасгах чинь ач холбогдолгүй гэж ярьж байна. Үгүй шүү, 1000 хүнтэй парламент үгүй ээ, үнэхээр 76-г бага гээд байгаа юм бол 20 хүнтэй л болгочихъя л доо. Тэгээд ажиллах чадамж байна уу? Ард түмний төлөөлөх үү. 20 хүнтэй болгочихъя л доо. Эсвэл 9 хүнтэй болгочих юм уу, 9 өрлөг гэдэг шиг нэг 9 сайхан өрлөг тавиад тэгээд Улс төрийн товчоо шиг хүмүүсийг тавьчихъя л даа. Тэгвэл улам л их ялзарна шүү дээ. Улам их авлигажна шүү дээ. Улс төрийн товчоо байж бид 9 хүнээр удирдуулж байсан, 1 хүнээр удирдуулж л байсан. Тэгэхээр ардчилсан нийгэм гэдэг бол олон хүний засаг бөгөөд олон хүний засаг гэдэг нь чамд таалагдах, таалагдахгүй тэр олонх, сөрөг, цөөнх гээд байгаа юм. Цөөнх ч биш л дээ, олонхын нөгөө тал л байхгүй юу, зүгээр, олонхын нөгөө тал болоод тэр нь муу хүмүүстэй биш арай илүү итгэл төрүүлсэн хэсэг нь тэр үедээ эрхээ аваад явж байгаа.

Тэр цөөнх гээд байгаа эрхээ авч чадаагүй эсэх нь бодлого хөтөлбөр нь яг удирдах тэр эрх мэдэлд хүрэхгүй болохоор нөлөөлөх чадамж өөрийгөө хамгаалах тэр бололцоог л хуулиар хийлгэх ёстой.

Тэгэхээр энэ Үндсэн хуульд юм оруулчихаар ганцхан болох гээд байгаа юм байна шүү дээ. Дараа дараачийн Сонгуулийн хууль одоо явж байна. Улс төрийн намын тухай хууль явж байна. Сая Ерөнхий сайд өчигдөр Оюун-Эрдэнэ маш том мэдэгдэл хийлээ шүү дээ. Сонирхлын зөрчлийн хууль гээд Тэмүүжин гишүүн бид 2012 оны 1 сард батлуулж байсан. Би Байнгын хорооны дарга байхдаа үүнийг авч гарч байсан, хэцүү л байсан, манай Их Хурлын гишүүд, намын гишүүд маань ч гэсэн дургүйцэж л байсан. Тэгэхэд тэр сонирхлын зөрчлийн хууль гэдэг чинь юу юм гэхээр тодорхой хэмжүүр шалгуур байхгүй юу. Тэр анги хамт олон, найз нөхөд, бусад бүх хүнийг тэр асуудлуудыг ажлын үеэр нь хийх хязгаарлалтуудыг нь хийж өгсөн юм аа. Одоо Ерөнхий сайд юу хэлж байна вэ гэхээр дахиад парламентыгаа

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

цэвэршүүлж, дээрээсээ эхэлье ээ, парламентаасаа эхэлж, юмаа өөрчилье өө гээд системтэй олон ажлууд авлигатай тэмцэх ажлуудыг хийж байна. Түүнийхээ хүрээнд Их Хурлын гишүүн, сайд нар, төрөл садан хүүхдүүд нь ингээд тендерт оролцохгүй байх. Тэгээд мөн удирдах албан тушаалд хүнээ хүүхдээ томилуулахгүй байх гэдэг юм уу энэ нь эхэлж байгаа нь бусдыг бүгдийг нь нэг зэрэг зохицуулах гэж байгаа биш байхгүй юу даа. Дөнгөж эхлэл, энэ бол түүхэн эхлэл болно. Ингээд юм чангарч байгаа, юм сайжирч байгаа чинь хоорондоо холбогдоод явж байгаа. Ганцхан Үндсэн хуулийн энэ явж байгаа юм биш. Өчигдрийн тэр Сонирхлын зөрчлийн хууль ч гэсэн энэ Үндсэн хуулийн заалттай холбоотой. Улам бүр парламентын гишүүн болох нь бэрхшээлтэй болох ёстой. Төр, бизнес 2 тусдаа больё гээд байна шүү дээ.

Тэгэхээр парламентын гишүүнд тавигдах хязгаарлалт, хориглолтууд улам их нэмэгдэх тусам парламентын гишүүн нь жирийн ард түмэнтэйгээ адилхан тэр хэмжээ рүү очиж явах ёстой. Харин бидэнд байгаа хамгийн том эрх мэдэл байгаа. Тэр нь ард түмнийг төлөөлж, тэдний өмнөөс шийдвэр гаргадаг тэр эрх мэдлийг хэнбугай ч харин авч болохгүй. Тэр хэмжээгээрээ энэ Монголын парламент хүчирхэгжих ёстой. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд Монгол Улсын цаашидын хөгжлийн үндсэн баталгаа бол парламентын ардчилсан тогтолцоо мөн гээд заачихсан. Парламент дотор асуудал алдаа байгаа бол засаж бэхжүүлж явах ёстой болохоос биш парламентыг үгүйсгэх замаар явахгүй. Парламентын суурь хүчин чадлын гол хэсэг нь улс төрийн намууд байдаг. Тэгэхээр энэ улс төрийн намууд муу байна. Хамгийн муу учраас намын жагсаалтаар оруулж ирэхийг хориглоно гээд байгаа байхгүй юу. Буруу байхгүй юу. Мууг засаж байж үндэс нь хаанаа байна вэ гэхээр нам дээр байгаа нь үнэн. Нам, ард түмний холбоо, нам, гишүүдийнх нь

холбоо суларсан байгаа нь тэдгээрийн өөрсдийнх нь буруу. Гэхдээ бид хуулийн хүрээнд зөв болгох ёстой байхгүй юу эхлээд. Тэгэхээр энэ асуудал дээр миний хэлэх гэж байгаа гол санаа бол би өнөөдрийн хүнд ч зориулж хэлж байгаа юм биш. Энэ УИХ-д ороод би 8 жил завсарлалчаад ч орж ирж байсан. Намынхандаа ч хатуу үг хэлж явсан, удирдлагаа ч шүүмжилж явсан. Хэзээ ч үзэл санааны хувьд хэн нэгэн даргад юм уу, хэн нэгэн улсуудад боолчлогдож яваагүй. Үндсэн хууль бол энэ хуульч болж энэ Их Хуралд орж ирснийхээ хувьд дуу хоолойгоо илэрхийлж надад олдсон миний хамгийн том надад боломж, бахархал энэ ард түмний надад өгсөн итгэл. Энэ итгэлтэй үед Үндсэн хууль бол энэ ард түмний хамгийн чухал амин зүрх дархлаа. Үндсэн хуульд хүрнэ гэдэг хүний тархи, зүрхэнд мэс засал хийж байгаатай адилхан, үнэн.

Тэгэхээр энэ асуудал дээр би байр сууриа маш тодорхой ингэж илэрхийлэхийг хүсэж байгаа юм. Тэгэхээр бид юу болж байгаа юм бэ гэхээр түрүүн хэлдгээр парламент нь болохгүй байна, намууд нь болохгүй байна гэвэл засвар хийж байгаа олон ажлуудын нэг нь том ажил явагдаж байна. Энэ бол хэлэлцүүлэг, боломж, энэ бол тулгалт биш муйхарлал биш шийдэл нь эцсийн дүндээ хамгийн зохистой хэмжээнд очих ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа.

Тэгээд төгсгөлд нь хэлэхэд энэ сонгуулийн холимог системээр пропорциональ системээр бид 12 онд явж үзсэн, бүгдийг нь үзчихсэн байхгүй үзээгүй шүү. Цэцийн шийдвэр гараад хаалттай жагсаалт болгочихсон юм. Би бид нарын нээлттэй байсныг. Тэр үед бүр 12 онд СЕХ нэг буруу юм хийсэн нь намын жагсаалтыг хавсаргаж, саналын хуудасны хажууд хийгээгүй юм. Бид тэгж хүсээгүй юм, тэгээд явчихсан юм. Тэгээд хүмүүс жигшээд байгаа юм. Зүй нь бид намууд намын жагсаалтаа ард түмэнд зарлана, саналын хуудасны ард хавсаргана тэгээд нам дээр дүн тавих

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ёстой байхгүй юу. Энэ хийгдээгүйг буруутгах үндэслэл болгож болохгүй. Бид эхний үед Цэцтэй холбогдоод тухайн үеийн улс төрийн байдалтай холбогдоод муу хувилбараар эхэлсэн ч гэсэн бид нэг алхсан юм. Алхсан учраас 2008 оны 7 сарын 1-ний явдал 12 онд давтагдаагүй юм. Тэр үед сонгууль болохгүй, чадахгүй гэж байсан үе байхгүй юу. Тэрийг бид засаж бас давж гарсан юм шүү. Өнөөдрийн өндөрлөгөөс бүгдийг дүгнэх амархан, өчигдрийг тэгэхдээ мартаж болохгүй. Бид дандаа урагшаа харах ёстой. Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн тавьж байгаа асуудал намаасаа, парламентаасаа, засгаасаа бүгдийг эхэлье, тэгээд цаашаагаа бусдад ... /минут дуусав/

Д.Тогтохсүрэн: Сарангэрэл гишүүн үг хэлнэ.

Д.Сарангэрэл: Товчхон үг хэлье ээ. Би дахиад л түрүүнийхээ үгийг давтах гээд байна л даа. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна, Үндсэн хуульдаа гар хүрнэ гэдэг бол зөвхөн парламентад суудалтай намуудын дангаараа хийдэг ажил биш ээ. Энд парламентын гадна талд байгаа болон иргэд, сонгогчид, Монголын ард түмэн бүгд дуу хоолойгоо оруулах, саналаа хэлэх, улмаар бас тодорхой хэмжээнд нэгдсэн 1 ойлголтот дийлэнх олонх нь хүрсэн байх ёстой. Энэ нь өөрөө элдэв эрсдэлээс улс орныг, улс төрийг, парламентыг хамгаалах ийм үүд хаалга болно оо гэдэг үүднээс би тайлбараа хэлээд байгаа юм аа.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм шаардлага байгаа гэдгийг хувь хүнийхээ хувьд ойлгож байгаа. Мэдээлэлтэй байна гэж би хэлээд байна шүү дээ. Харин үүнийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа олон нийтдээ энэ мэдээллүүдээ өгөх ёстой. Өнөөдрийн байдлаар ер нь үүнийг ганц тайлбарлаж хэлж байгаа хүн Доржханд гишүүн л байна шүү дээ. Өөр энэ ард иргэдтэйгээ ажиллаж байгаа хүн байгаа юм уу? Хаа нэгтээ энд тэнд нэг хэлэлцүүлэг болж

байх шиг байна. Тэр болгоныг нь бас хүмүүс үзэж хараад сонсоод байгаа зүйл байхгүй байна.

Тийм учраас өнөөдөр яагаад бид Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт хийх ёстой вэ, яагаад УИХ-ын гишүүдийн тоог 152 болгох ёстой вэ, яагаад бидэнд холимог тогтолцоо шаардлагатай байгаа вэ гээд ингээд нэг бүрчлэн сая хэлээд байна лээ. Тийм ээ, улс төр талаас нь, шинжлэх ухааны талаас нь, үндэсний аюулгүй байдал талаас нь, нийгэм, эдийн засгийн асуудал байна уу үгүй юу? Ингээд бүх талаас нь 1, 2, 3, 4, 5, 6 гээд хэд байдаг юм? Энэ тайлбаруудаа хийх ёстой, энэ ойлголтуудаа өгөх ёстой. Ингээд нэгдсэн 1 ойлголтот хүрэх юм бол цаашид бидний нөгөө явах гээд байгаа тэр сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх, нийгэмд тогтвортой байдлыг бий болгох гээд олон талын алсын хэд хэдэн чухал зүйлүүдийг бид нар харж байж үүнд бас нэмэлт, өөрчлөлт хийх ёстой гэдэг ийм л байр суурийг хэлээд байгаа болохоос биш үүнийг ойлгохгүй юм уу тас эсэргүүцээд байгаа зүйл байхгүй.

Саяын зүйлүүдийг нэг бүрчлэн нэлээн прагматик хандлагатай байгаад бүгдээрээ ажиллаад тэгээд би олон хэлэлцүүлгүүд явна гэж ойлгоод байгаа шүү дээ, Энхболд дарга аа, Тогтохсүрэн дарга аа. Тэгээд үүний дараа парламент өөрөө нэгдсэн ойлголттой болмоор байна шүү дээ. Өнөөдрийн энэ Байнгын хорооны хурлыг харж байхад дор бүрдээ л өөр өөрийн гэсэн тайлбарууд, өөр өөрийн гэсэн байр суурийг хэлж байна. Бид ийм байхад ард иргэд маань ямар ойлголттой байх билээ. Эдгээрийг бид нар нэлээн ойртуулж байж, нэгдсэн ойлголт руу тодорхой хэмжээнд хүрч байж, энэ асуудалд хандах ёстой гэдэг энэ байр суурийг би дахин илэрхийлж байна. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа. Ганболд гишүүн.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Г.Ганболд: Бид нар яах вэ, Үндсэн хуульдаа ойрхон ойрхон гар хүрээд л байна, өөрчлөлтүүд хийгээд л байгаа. Тэгэхдээ энд бид нар нэг Үндсэн хуулийн суурь зарчмаа ер нь жаахан эвдээд л яваад байгаа юм. Давхар дээлийг оруулж ирээд, Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад өөрсдийн бүрэн эрхийн хугацаандаа өөрсөд дээрээ хэрэгжүүлээд л яваад байгаа. Одоогийн энэ Үндсэн хуулийн өөрчлөлт мөн л бид нар өөрсдийнхөө бүрэн эрхийн хүрээнд л оруулж ирээд, магадгүй нийгэм бол эд нар энд гишүүдийн тоог нэмээд одоо энэ байгаа гишүүд нь жагсаалтад ороод явах гэж байна гээд ийм л зүйл яриад байгаа юм л даа. Би суурь зарчим гэж юу яриад байгаа юм гэх дээр зэрэг хэрэв энэ нь Үндсэн хуулийн өөрчлөлтүүд ороод явах юм дараагийн парламент магадгүй, энэ удаа бид нар гишүүдийн тоо ярьж байгаа бол дараагийн парламент магадгүй 4 жил цөөн байна, 10 жил болгоё оо. Тэгээд энэ удаагийн өөрсдийн парламентаасаа иүүд хугацаагаа сунгаад явъя гээд Их Хурлын 4 жилийн хугацааг 10 жил болгоод өөрсөд дээрээ хэрэгжүүлээд явахад бид нар хэлэх үггүй л болж байгаа юм л даа. Эсэргүүцэх боломжгүй. Энэ агуулгаараа би бол суурь зарчим эвдэгдээд байна л гэж хэлээд байгаа юм.

Тийм учраас яах вэ, энэ 152 болгох зүйлүүдийг оруулж ирж байгаа үндэслэл зүйлүүдийг нь ойлгож байна. Тэгэхээр зэрэг энэ нийгмийн хардалтаас шалтгаалаад ч гэдэг юм уу, ер нь хэрэгжих хугацааг нь 2028 оноос бид нар өөрсдийнхөө бүрэн эрхэд хамааралгүй ингээд хэрэгжүүлээд явах ийм боломжуудыг ч гэсэн бид нар харах л ёстой гэж бодоод байгаа юм.

Тэгээд энэ оруулж ирж байгаа хүмүүсийн ингээд би зүгээр яах вэ, үндэслэл шалтгаануудыг нь харж байгаад жаахан буруу л тайлбарлаад байна даа. Ер нь ингээд нэг математик аргачлал, тэгээд 1 ижил төстэй улс орнуудын хүн амын тоотой харьцуулаад нэг юм оруулж ирээд байх юм. Энэ чинь зөвхөн хүн ам

биш шүү дээ. Хүн амын тоо, төсвийн хамаарал, газар нутгийн хэмжээ олон зүйлээс хамаардаг зүйл шүү дээ. Бид нар Скандинавын орнуудын манайхтай ойролцоо нэг 4, 5 сая хүнтэй хүмүүстэй харьцуулж байгаа тэд нарыг чинь Жи Ди Пи 1 хүнд ноогдох ДНБ нь манайхаас 100 дахин их улсууд шүү дээ. Тэд нарын хувааж хуваарилж байгаа хөрөнгө мөнгө асар их. Тэр агуулгаар нь ер нь энэ нийгэмд энэ Их Хурлын гишүүд, ард иргэдэд тайлбарлаж явахад нэг жаахан үндэслэлтэй юмнууд та нар гаргаж өгмөөр байна аа. Хүн амын тоогоор ярих юм бол саяын гишүүдийн хэлж байгаа Энэтхэгийн чинь парламентын гишүүд нь 1 гишүүн нь бараг 3 сая шахуу иргэн төлөөлдөг юм байна лээ шүү дээ. Манай Монгол Улсын бараг бүх хүнийг нэг л хүн төлөөлөхөөр. Тэгээд ийм үндэслэлүүдээ нэг жаахан өөр зүйлээр ярьж явахгүй бол зөвхөн үүнийг яриад байгаа нь буруу.

2 дугаарт нь, ингээд 1 гишүүн 3, 4 Байнгын хороонд орчхоод байна гээд тайлбарлаж байгаа чинь ч бас буруу шүү дээ. Бид нар сая парламентаараа л 3, 4 Байнгын хороог бараг хүнд зориулаад л байгуулчихсан, хэрэггүй шахуу олон давхардсан Байнгын хороод байна. Тэгээд үүнээсээ болоод үүнийгээ ингээд болохгүй зүйлийн шалтгаан болгож яриад байгаа нь өөрөө буруу байхгүй юу.

Ер нь сонгодог парламент гэж дэлхий дээр хаана ч байхгүй. Бид нарын яриад байгаа энэ Солонгосын парламент гээд арай нэг жаахан ойр дотно бидэнд наалдаад байгаа зүйл нь Солонгосын парламент бол 1 гишүүн 1 Байнгын хороонд харьяалагддаг. Тэгээд хуулийн хэлэлцүүлгүүд нь яг мэргэжлийн Байнгын хороон дээрээ явагдаад, чуулган дээрээ соёрхдог гэдэг нь маш оновчтой байгаа юм. Энэ агуулгаараа бид нар 1 Байнгын хороонд харьяалагдаад зөвхөн тэр Байнгын хорооныхоо асуудлаар мэргэшдэг, тэр асуудалдаа нухацтай ханддаг. Сэтгүүлчид ядаж ирээд юм асуухад өөр Байнгын хорооны асуудлаар бараг хариулт өгдөггүй, Солонгосын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

парламентын гишүүд. Яагаад гэхээр мэдэхгүй учраас тэрийг хариулдаггүй. Гэтэл манайхан өнөөдөр парламентын гишүүд нь эрчим хүч яривал эрчим хүч ярина, уул уурхай яривал уул уурхай ярина, эрүүл мэнд, боловсрол, үгүй ээ, мэдэхгүй юм байхгүй, бас дээр нь мэдэх юм ховорхон. Үүнийг чинь өөрчлөх гэж би яг энэ олон гишүүнтэй болгож, парламентын гишүүдийг мэргэшүүлэх тал руу нь тайлбарлаад явах юм бол би илүү иргэдэд хүрнэ гэж ингэж ойлгоод байгаа юм аа.

Тэгээд энэ чиглэл рүү оруулаад явахгүй бол ингээд бас нэгэнт ингээд Үндсэн хуулийн өөрчлөлт ярьж байгаа бол бид нар нэлээн нийгэмд өмнө нь яригдаж байсан ноднин уржнан хэлэлцүүлэг яваад л байсан, эсвэл тэр нэг төрийн сүлдний ганц нэг юмаа нэмээд хэлэлцүүлээд явчихвал ер нь яадаг юм бэ? Бид нар чинь ингээд Үндсэн хуулийн хэлэлцүүлэг яваад ирэхээр ард иргэдээр бүгдээрээ явна, олон хоногоор хэлэлцэгдэнэ. Энэ хүрээнд нэг нийгмийн шүүмжлэлтэй байдаг, нөгөө талаасаа ард иргэдийн бас дэмжлэг аваад байдаг ийм нэг зарим нэг зүйлүүдээ бас энэ ганцхан тоо хөөцөлдөхгүй давхар яриад явчих юм бол бас магадгүй зарим нэг хүмүүсийн дэмжлэгийг авах, тэгээд зөвхөн нэг өөрсдөө нэг тоо нэмэх гээд байгаа юм шиг ийм байдлуудаас ингээд гараад явахад арай дөхөм юм болов уу гэсэн ийм л зүйлийг хэлэх гэсэн юм.

Н.Энхболд: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүн.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр бид нар энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр парламентынхаа төлөөлөх чадварыг хангах буюу ард иргэдийнхээ төлөөлөх энэ боломжийг нэмэгдүүлэх маань гол зорилт байгаа гэдгийг хэлмээр байна. Ер нь парламент бол хууль батлахаас гадна иргэдээ төлөөлөх ёстой. Тэр дотроо хүн ам цөөнтэй, өргөн уудам газар нутагтай зах хязгаар нутгуудад хүн амын суурьшил маш сийрэг болж байгаа. Төв рүү шилжих хөдөлгөөн ихэссэн энэ

Монгол Улсын хувьд бид нар энэ парламент бол газар нутгаа ч төлөөлж байх ёстой давхар хүн амаа ч төлөөлж байх ёстой гэдэг энэ үндэслэлээр энэ холимог системийг нэвтрүүлэх нь асар чухал байна аа.

Өнгөрсөн 30 жилийн 7 удаагийн сонгууль буюу энэ мажоритарар явж ирсэн парламентын энэ тогтолцоо зөвхөн газар нутгаа төлөөлж байсан. Харин хүн амын төлөөллийг орхигдуулж ирсэн гэдгийг энэ өмнөх гишүүд маань зөндөө хэлж байна. Тэгээд хүн амыг төлөөлөхгүй байгаа тохиолдолд энэ УИХ-ын маань олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөх легетим чанар алдагдана аа. Түүрүүн Нямбаатар сайдын үгэнд бас тодорхой дурдагдсан. Ер нь энэ парламент бол жил жилийн сонгуулиар нэг нийт сонгогчдынхоо нэг 60 орчим хувийн төлөөллийг хангаад, 40%-ийн санал гээгдэж ирсэн. Тийм учраас энэ алдаагаа бид нар засаж, холимог систем нэвтрүүлэх нь зүйтэй.

Дээр нь гишүүдийн тоо нэмэх нь бас их үндэслэл байгаа юм аа. Геополитикийн нөхцөл байдал, хөрш орнуудын бодлого, дээр нь дэлхийн улс орнууд дахь олон улсын эрх зүйн зарим хэм хэмжээг зөрчсөн үйлдлүүд үнэхээр тод харагдаж байна. Жижиг улсын хувьд бид нар эдийн засгийн болон бусад томоохон хөтөлбөрүүд, хөрөнгө оруулалт дээр улсын гадаад болон дотоод нөлөө их байна аа. Тэгэхээр энэ нөхцөлд парламент нь аль болох олон иргэдийнхээ дуу хоолойг хангасан, хүмүүсийн байр суурийг жигд илэрхийлсэн тэр дотор нийгмийн бүлгүүдийн төлөө хангасан байх ёстой.

Ингээд 30 жилийн хугацаанд манай парламентыг харахад нэг ч удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн орж ирээгүй. Өөрөөр хэлбэл өнөөдөр байгаа энэ тогтолцоо чинь, энэ өндөр зардал бүхий сонгуулийн систем чинь, зөвхөн тойргоор төлөөлөл орж ирдэг. Энэ сонгуулийн систем чинь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг оруулж ирэх

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

боломжийг өгөөгүй байна. Дээр нь залуучууд, эмэгтэйчүүдийн төлөөлөл маш доогуур байна. Зардал өндөртэй энэ сонгуулийн тогтолцоог бид нар өөрчлөх ёстой. Тийм учраас намын жагсаалтаар, намын листэд тухайн нийгмийн бүлгүүдийн төлөөлөл орж ирдэг эрдэмтэд, академикуудын төлөөлөл, эмч, багш нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэн маань тэнд байж байх ёстой. Тэгэхээр энэ болгоныг бид нар өнөөдөр засах цаг нь яах аргагүй мөн байна аа.

Тийм учраас энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн гишүүдийн тоо нэмэх гэж байгаа гэж харж болохгүй. Бид нар давхар улс төрийн намын шинэчлэлийг, сонгуулийн тогтолцооны том шинэчлэлийг хийх нь чухал байна аа. Сонгуулийн зардлыг бууруулах, сонгууль дахь хөрөнгө мөнгөний нөлөөг багасгах, мөнгөтэй хүмүүс тухайн жижиг тойргийг усалж гарч ирдэг. Тойргийн иргэдэд бэлэг сэлт тарааж, мөнгөөр дамжуулан улс төр хийдэг энэ байдлыг халах нь энэ сонгууль дахь намын лист буюу пропорциональ системийг оруулж ирж байгаа гол үр дүн байгаа.

Ер нь энэ тогтвортой ардчилсан улс орнуудын жишигээс харахад манайхтай нэг гараанаас гараад зарим нь алдаж оноод дарангуй систем рүү орчихсон. Зарим нь маш амжилттай яваад байгаа энэ зүүн Европын улсын жишигээс харахад ерөөсөө сонгуулийн холимог юм уу пропорциональ системтэй байна. Тэр улсуудын парламентын төлөөлөл нь хүн ам аль болох жигд төлөөлсөн байна. Энэ бүгдийг харахад яах аргагүй өнөөдөр бид нар энэ алдаагаа засах цаг нь болсон.

Дараагийн нэг үндэслэл бол энэ парламент дахь намын жагсаалт, парламентын гишүүдийн тоо гэдэг бол нэгэн зэрэг Монголын улс төрийг хөгжлийн бодлого ярьдаг бодлогын улс төр хийх боломжийг олгож байгаа юм аа. Тийм учраас бид нар зөвхөн энэ өнөөдөр

байгаа энэ 76 гишүүн бүхий парламентаар ер нь дэлхийн парламентыг төлөөлөн харж болохгүй юм аа. Парламент бол бодлогын мэтгэлцээн хийдэг, бодлогын улс төр ярьдаг, тэнд урт хугацааны бодлогоор өрсөлддөг, парламентын сонгууль нь ч гэсэн ийм бодлогын өрсөлдөөн байх ёстой. Үүнийг засахын тулд бид нар энэ холимог систем болон гишүүдийн тоо нэмэх асуудлыг ярихаас өөр аргагүй байна.

Ер нь урт хугацааны бодлого ярихгүй байсны улмаас энэ 30 жилийн энэ тойргоор тарамдуулсан бодлого чинь хөгжлийг гацаасан байна. Хэдийгээр бид нар яах вэ бүс нутагтаа ардчиллын үзүүлэлт харьцангуй гайгүй байгаа гэж явж байгаа болов чиг цаг алдсан олон зүйл байна. Тойргийн энэ хуваагдсан систем ерөөсөө стратегийн бодлогуудыг явуулах боломж өгөхгүй байсан. Тэгээд өнгөрсөн жилүүдийн миний хувьд эрдэмтэн байх үедээ хийж байсан судалгаануудад үндэслэсэн тэр байр суурь маань ч гэсэн хэвээр байна. Яаралтайгаар бид нар энэ бодлогын улс төрийг оруулж ирэх ёстой. Үүний тулд бодлогын намуудыг бий болгох, нам бол зөвхөн нэг хэсэг бүлгийн гэдэг юм уу тухайн намд элссэн гишүүдийн албан тушаал хөөх, эрх мэдэл ойртох энэ боломжийг арилгах ёстой. Иргэдийн маань дунд ч гэсэн хүлээлт өндөр байна. Намаар дамжсан улс төр цэвэр бодлогын өрсөлдөөн байх ёстой. Тэнд бодлого ярьдаг бодлогын улс төрчид парламентад орж ирэх ёстой.

Тийм учраас энэ өнөөдрийн энэ Үндсэн хуулийн шинэчлэл, улс төрийн намын шинэчлэл, сонгуулийн шинэчлэл нэгэн зэрэг цуг явах ёстой учраас эдгээрийг цогцоор нь харж хийх ёстой.

Дараагийн нэг асуудал нь миний хувьд УИХ-д Улаанбаатар хотоос буюу СБД-ээс сонгогдсон гишүүн. УИХ дахь нийслэлийн төлөөлөл өнөөдрийн парламент дахь нийслэлийн төлөөлөл маш цөөн байна. Хүн амын маань тэн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

хагас нь нийслэлд амьдарч байна. Энэ хэмжээгээр агаарын бохирдол, замын түгжрэл, сургууль, цэцэрлэгийн хүртээмж, нэг анги дахь 50, 60 хүүхэдтэй асуудлаа бид нар ишийдэх ёстой. Гэтэл энэ тойргоор хуваагдсан системээс болоод хүн ам хаана байгаа, тэр лүү бодлого тогтвортой явахгүй байна. Төсвийн хуваарилалт маш тарамдаж байна. Тийм учраас нийслэл дэх парламентын гишүүдийн тоог нэмэх зүй ёсны шаардлага байна. Яг өнөөдрийн 76 гишүүний тоог ингээд харахаар нийслэлийн гишүүд бид нар ерөнхийдөө нэг 99377 сонгогчийг төлөөлж байгаа шүү, 1 гишүүн бол. Гэтэл хөдөөгөөс орж ирсэн гишүүд маань 55315 сонгогчийг төлөөлж байна. Энэ хэмжээгээр бид нар нийслэлийн иргэдэд ачаалал ихтэй нийслэлийн гишүүдийн хүлээх асар их хариуцлага байна. Тэгэхдээ бид нар үүнийг гишүүдийн тоог нэмж байж, мөн сонгуулийн холимог системийг оруулж ирж байж ишийдэхгүй бол өөр хувилбар алга.

Нийслэлд хүн, амын асар олон асуудал байна. Энэ болгоныг ишийдэхийн тулд манай иргэд маань тоо нэмэх болон тогтолцооны асуудлыг зөвөөр ойлгоосой гэдгийг хэлмээр байна.

Ер нь парламент маань иргэдээ тэгш төлөөлж байж, илүү хүртээмжтэй улсыг бий болгоно. Тэнд хүм, амын маань дуу хоолой илүү хүчтэй хүрнэ. Энэ тал дээр бол гишүүний хувьд улам хүчтэй ажиллах боломжийг өгнө. Хамгийн сүүлд ер нь бол улс төр гэдэг бол хэн нэгэн хувь улс төрчийн ганцаарчилсан тоглолтын орон зай биш, энэ бол багийн улс төр явах ёстой. Бодлогын улс төр явах ёстой. Тийм учраас бид нар энэ хөрш улс орнууд, мөн Азийн бусад улс орнууд, нэг гараанаас гарсан пост, коммунист улс орнуудын аль болох сайн жишээг бид нар нэвтрүүлэх шаардлагатай. Энэ дээр бол бодлогын улс төрийг бий болгох хамгийн чухал үндэслэл бол энэ холимог систем. Гишүүдийн тоо нэмэх асуудал байгаа.

Тийм учраас улс орны хөгжлийн бодлогыг бодсон, ирээдүйгээ харсан, зөвхөн тойргийг харахгүйгээр хэн гэдэг гишүүн тухайн тойргоос хэдэн удаа сонгогдсон гэдгийг харахгүйгээр бид нар бодлогын алсын хараатай улс төр хийх ёстой. Тийм учраас энэ дээр өнөөдрийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Улс төрийн намын тухай хуулийн шинэчлэл, Сонгуулийн систем маань чиглэж байгаа гэдгийг харах нь зүйтэй байна.

Н.Энхболд: Баярлалаа. Батсуурь гишүүн үг хэлье.

Ж.Батсуурь: Баярлалаа. Тэгэхээр бид нар Монгол Улсын Үндсэн хуулийг өөрчлөхийг ярьж байгаа. Монгол Улсын Үндсэн хууль бол Монгол Улсын л асуудлыг тойрч ярих ёстой. Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлэх асуудлуудыг ярих ёстой гэж бодож байгаа юм. Тэгэхээр Үндсэн хуулийг хэлэлцье. Хэлэлцье гэж байна. Тэгээд хэлэлцье гэдэг чинь ярилцъя гэсэн үг. Тэгэхээр энд яригдаж байгаа зүйлүүд эрдэмтэн, мэргэд, судлаач нар, мэргэжлийн хүмүүс гээд ингээд тайлбар өгч байгаа хүмүүс бол улс төрч нарт хэт бурантаглагдаж байна. Хөтлөгдөж байна. Энд сууж байгаа та бүхнийг хэлж байна. Яагаад вэ гэхээр телевизийн мэтгэлцээн, зүйлүүд ярихад сүүдэртэй талыг нь ерөөсөө огт ярихгүй байгаа юм. Дандаа л нартай сайн сайхан зүйлийг нь. Эхлээд нөгөө юугаа авчихсан. Зорилго добро-оогоо авчихсан. Тэгээд тэрэндээ зориулж эзэндээ таалагдах гэж ингэж ярьдаг. Математик ч байна уу, судлаач байна уу, эрдэмтэн байна уу та нар муу талуудыг нь бүгдийг нь мэдэж байгаа шүү дээ. Тэгсэн мөртөө дандаа сайн талыг нь дарга аа, миний хэлсэн ямар болсон, гоё болсон уу, ахиж яаж гоё яриулмаар байна вэ гэсэн байр сууриас хандах юм бол явахгүй. Жишээлэх юм бол энэ олон тайлбарууд үнэхээр сонин сонин тайлбарууд гарч ирж байх юм. Нэг гишүүний кноп үнэ цэнтэй байна. Худалдагддаг гэнэ. Гишүүн худалдагдахыг хэн мэдсэн юм, хэн харсан юм. Хэрвээ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

худалдагдсан бол тэр гишүүнээ Авлигатай тэмцэх газарт яагаад өгөөгүй юм. Манай намд бол худалдагдаад байх ч олон хүн байхгүй. 11 л хүн байгаа. Тэр олон газраа худалдагдсан бол тэрийгээ яагаад шалгуулахгүй байгаа юм. Худалдагдсаныг нь мэдсээр байж байж яагаад саналыг нь аваад байдаг юм ч гэдэг юм уу ийм асуудлууд гарч ирж байгаа юм.

Дээр нь гишүүдийн тоо олонх болохлоор чанар улам муудна шүү дээ. Одоо бид нар ингээд үг авангуут, ингээд 76 гишүүнтэй байхад нэг асуудал ороод ирэнгүүт 20 гишүүн кноп дарахад, 1 хүн 5 минутаар гэхэд 100 минут буюу 1 цаг 40 минут, хариулт нь 1 цаг 40 минут. Ингээд нэг асуудалд хариулахад бид нар 3 цаг 20 минут зарцуулж байгаа байхгүй юу. 152 гишүүн ороод ирвэл ямар болох вэ. Дэгт өөрчлөлт оруулна гэдэг чинь хүний хэлэх боож байна л гэсэн үг шүү дээ. Өнөөдөр би мачийгаад, мачийгаад 30 жил бас энэ улс төрд явсан. Би 3 минутад үгээ эвлүүлж хэлж чаддаггүй. Шинэ хүмүүс орж ирээд 1 минутад улс орны хэмжээний асуудлыг би хэлээд ойлгуулчихна гэж бодохгүй байна.

Дахиад нэг зүйл байгаа юм. Энэ холимог системээр явах сайн талууд зөндөө бий. Мэдээж сайныг нь та нар бүгдийг нь ярьж байгаа болохоор би муу талыг нь ярь. 2012 онд холимог бөгөөд гулсдаг системээр явсан. Би намын дарга байсан. Би тэгээд яг энэ холимог системийн жагсаалтад малчин, тариачин, багш гээд улс төрд байгаагүй эрдэмтэн, доктор гээд хүмүүсийг бүгдийг жагсаасан. Тэгсэн чинь 10 орчим хүн жагсаалтаар ороод ирж байгаа юм. Ороод ирсэн хүмүүс яадаг вэ гэхээр тэнд дарангуйлал тогтчихдог. Яасан гэхээр намын дарга өргөвөл өргөдөг, өргөхгүй бол өргөхгүй. Ерөөсөө өөр аргумент гаргаж ирж ярихгүй. Намын дарга л хаана байна вэ түүнийг дагаад л, ингээд л сүүдэр шиг дагаад байдаг. Тэгэхээр энэ бол бас ингээд холимог системийн хуульчлагдсан дарангуйлал үүсэх магадлалтай. Жишээлэх юм бол би ХҮН

намыг бүлэгтэй болох байх гэж бодож байна. Энэ системээр. ХҮН намын жагсаалтад орсон хүмүүс Доржхандыг бие засахаар явахад аягүй бол дагаад явна. Яагаад вэ гэхээр бүгдийг түүгээд тавьчихсан юм чинь. Доржхандын хэлсэн үгнээс зөрж хэлэх хүн тэр жагсаалтаас гарч ирэхгүй. Ингээд нөгөө барууны үзэлтэй шинэ, үеийн сайхан залуу дарангуйлагч болно. Өнөөдөр дарангуйлагч болдгийг чинь давхар дээлээс бид нар олж харж байгаа байхгүй юу. Хүнээсээ болдоггүй систем чинь өөрөө дарангуйлагчийг төрүүлдэг байхгүй юу. Өнөөдөр Доржханд олон сайхан зүйлүүд ярьдаг. Тэгэхдээ энэ гадаадад явсан, олон улсаар тойрсон гээд. Нэр нь мэдэгдэхгүй, хэн ч мэдэхгүй улсуудын жишиээнүүдийг ярьдаг. Тэр хүмүүсийн амьдралын чанарыг өөрчлөхгүйгээр бид нар Монгол Улсын энэ 1 сая 500 гаруй километр квадрат нутагт байгаа цөөн 300 хэдэн сум, мянга гаруй баг, хорооны хүмүүсийн амьдралын чанарыг л ярих гээд байгаа юм. Зарим зүйл дээр бид нар санал солилцож байсан. Жишээлэх юм бол хөдөөд хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад атрын аян явж байхад, нэгдэлжих хөдөлгөөн өрнөж байхад хамгийн түрүүнд Соёлын төв улаан булан барьж байсан. Яагаад вэ гэхээр тэнд залуучуудын амьдрах орчин сайн сайхан зүйлийг авчирдаг. Хотоос хөдөөд очсон хүн ард түмэнд үгээ ойлгуулахад хамгийн түрүүнд соёлын төв хэрэгтэй байдаг. Тэгвэл манай Доржхандын үгнээс дандаа соёлын төв байх хэрэггүй, соёлын төвгүй л бол Монгол улс хөгжчих юм шиг. Хөдөөд ийм үг байдаг. Хотоос ирсэн хүн хоргойноос сонин байдаг гэж. Тэр хоргой шиг сонин юмаа хаана очиж ярих юм. Айлаар хэсээд яриад юу ч болохгүй. Соёлын төвд л очиж ярина гэх мэтчилэн амьдралаас чанаржсан хүмүүсийг ийм хуульчлагдсан дарангуйлагч болгочих вий дээ гэсэн ийм зүйлүүд байж байгаа.

Гэхдээ энэ системийн сайн талуудыг та нар өөрсдөө зөндөө яриад байгаа учраас би зүгээр болгоомжлуулах үүдлээс ярьж байгаа болохоос биш

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

эсэргүүцэхийн тулд эсэргүүцэж байгаа зүйлүүд энд байхгүй. Хэрвээ бид нар энэ зүйлүүдээ хийгээд, хамтраад яриад амжилтад хүрлээ гэхэд Хөгжлийн банкны хэрэг дахиж гарах юм уу. Нүүрсний хулгай дахиж гарах юм уу. ЖДҮ, Төмөр замын асуудал дахиж гарах юм уу. Энэ гаргасан хүмүүстэй хариуцлага тооцож чадах юм уу. Ард түмэн бол тэрийг л хүсэж байгаа шүү. Долларын ханиийг буулгаж чадах юм уу. Үнийн өсөлтийг тогтоон барьж чадах юм уу. Одоо энэ зах, дэлгүүрүүдээр явахад, бизнесийн газраар явахад зээлийн хүүг л буулгаад өгөөч гэж байгаа байхгүй юу. Ерөөсөө зээлийн хүүг л буулгаад өгчихвөл бид нар та бүхнээс онцын хүсээд байх зүйл алга. Бага хүүтэй зээлийг олгоод бид нарт хөдөлмөрлөх, зүтгэх боломж нэмүү өртгөөсөө бид нар татвараа төлөөд цаашаа явах боломж байна гэсэн ийм л зүйлүүдийг ярьж хэлье гэж байгаа юм.

Тийм учраас би түүрүүнд хэлсэн. Нямбаатар сайдад энэ тэр олон сайхан зүйлүүдийг л яриад байна. Хэлж байгаа зүйлдээ эзэн нь болоорой Нямбаатар сайд аа. Та олон л юмыг ярьж байна шүү. Нөгөө эзэн нь юмаа мэдэж, эрэг нь усаа хашина гэдэг шиг хэлсэн зүйлдээ явах хэрэгтэй. Дээр нь дээр нь Ардын нам, Ардчилсан нам 2 бол өрхийн түвшинд бүтэцтэй нам шүү. Тийм учраас танай манай 2-ын итгэлцэл хэлсэн ярьсандаа хүрэхээс ирээдүйн улс төрийн замналууд, Монгол орны шинэчлэл, өөрчлөлтийн энэ үйл ажиллагаанууд бол маш их... Доржханд аа, би үгээ дуусгачихъя. Ингээд ярианы хүч сулруулаад хаячихлаа. Ер нь бол мөнгөө өгсөн нь хөгжмөө захиалдаг гэж би энэ телевиз, радиогийн хэлэлцүүлгүүд энэ сонсгол мэдээллүүдэд улс төрийн намын хэлэлцүүлгүүдэд орж байгаа эрдэмтэн, докторууд бол дандаа нэг талыг барьж ярьж байгаа. Математикч нар. Би ч гэсэн тоондоо муу байгаагүй бас нэг өөдөөс нь янз бүрийн юм яривал яриад л байна. Тэгэхдээ 152 гэдэг тоог тайлбарлаж чадахгүй байна шүү дээ. Тайлбарлаж чадахгүй байна. Тэгээд 108 гэнгүүт бурхны юу яасан ч гэх шиг. 99

ч гэх шиг. Бид нар ямар машины дугаар сонгох гэж байгаа юм уу. Азын дугаар сонгох гэж байгаа юм уу. Тийм учраас олон талаас нь ярилцах зүйл байх. Тэгэхээр бид нар азын дугаараар явдаг байсан бол, зүгээр хүссэн тоогоороо явдаг байсан бол тэгвэл 153 яагаад байж болдоггүй юм. 150-аас цааш хэрэгтэй юм бол. Тэгвэл 154 яагаад байж болдоггүй юм. Тэгэхээр энийгээ сайн тайлбарлаад, хамтран ярилцаад явъя. Тэгээд хэлэлцүүлэг гэдэг бол би ярилцлага гэж ингэж үзэж байна. Ялангуяа сөрөг хүчин та бүхнийг хүсээгүй тэр 60 орчим хувь байгаа шүү. Тэрний төлөөллийн үгнүүдийг бас сайн сонсоорой тэгээд амжилт хүсье гэж.

Н.Энхболд: Баярлалаа. Занданшатар дарга.

Г.Занданшатар: Гишүүдийн амрыг айлтгая. 5 минутад багтаагаад манай бас зарим гишүүд төгсийн төгс Үндсэн хууль хайгаад, эрэлд хатаад байгаа учраас ахин дахин Үндсэн хуульд гар дүрээд, дур зоргоороо авирлаад байгаа юм шиг ийм зарим яриа, өгүүлэл гарч байгаа учраас түүхээр зарим нэг тодотгол хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Ер нь бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийчхэнгүүт маргааши нь бүх юм сайхан болоод л гэрэл гэгээ асаад явчихгүй мэдээж. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Засгийн газрын үйл ажиллагаа тогтвортой болсон. 1.4 жилийн настай байсан бол Засгийн газарт эрх мэдлийг шилжүүлсэн, төсвийн эрх мэдлийг Улсын Их Хурал өөрийнхөө эрх мэдлүүдийг танасан, томилгооны эрх мэдэл танасан. Одоо харин тэр Улс төрийн намын тухай хууль, Ерөнхийлөгчийн хууль, Үндэсний баялгийн сангийн хууль гэх мэт хуулиудаа баталж, 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бодитойгоор амьдралд хэрэгжүүлэх ийм шаардлага бий. Энэ чинь ингээд органик хууль, тэгээд процессын хууль, тэгээд хууль тогтоож ёс болж

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

тогтоож байж энэ ардчилал Үндсэн хууль хөгжил тогтоож хэвшинэ, бэхэжнэ ээ. Ийм учраас энд төгсийн төгс биш юм аа гэхэд сайн Үндсэн хууль боллоо гэж тухайн үеийн танай намын дарга Лу.Гантөмөр, Батзандан нарын гишүүд тэр бүрэн зураглал дээр чинь ярьж байсан. Яагаад гэвэл төр засгийн тогтвортой байдлыг хангалаа. Харин зарим нэг юм дутуу хийх үлдчихлээ гэж ич бүгдээрээ санал нэгтэй үлдсэн. Тэр дутуу үлдсэн юм нь юу юм бэ гэхээр 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үеэр Монгол Улсын тухайн үеийн Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга, дарга нь орлогч дарга нь Ухнаагийн Хүрэлсүх тухайн үеийн Ерөнхий сайд, 2 намын дарга Эрдэнээ дарга, 2 намын бүлгийн дарга Эрдэнэбат, Тогтохсүрэн даргын нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаад, энэ ажлын хэсгээс Ерөнхийлөгчийн саналаар Улсын Их Хурал 1 танхимтай 108 гишүүнтэй байх бөгөөд 54 нь олонхыг төлөөлөх, 54 нь хувь тэнцүүлэх зарчмаар бас хослуулаад явуулна гэсэн санал орж ирээд, Төрийн байгуулалтын байнгын хороо дээр 57 хувийн саналаар дэмжигдээд, Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх үед ерөөсөө Үндсэн хуульд өмнө нь оруулсан 1, 2 дугаар хэлэлцүүлгээр дэмжигдсэн сонгуулийн тогтолцоо тогтвортой биш учраас энэ сонгогчдын боловсрол, ардчиллын боловсрол жигдрэхгүй, хэвшихгүй ёс болж тогтохгүй байна. Намууд ч төлөвшихгүй байна. Ийм учраас сонгуулийн жил эхлэхээс жил гаруйн өмнө энэ сонгуулийн тогтолцоог бүрэн өөрчилсөн тоо нэмэх асуудлыг больё гээд ингээд Ардчилсан намын бүлэг чуулганыг хаяж гарснаас энэ асуудал дутуу үлдсэн юм. Одоо энэ дутуугаа гүйцээх гэж байгаа учраас дахин дахин Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад байгаа асуудал биш ээ гэдгийг 1 дүгээрт тодотгож хэлье.

2 дугаарт нь, тэр үед Үндсэн хуулийн энэ загварын дагуу таны яриад байгаа энэ олонхын дарангуйлал гэж яриад байгаа юм. Энийг Үндсэн хуулийн эх

баригч нар, анхны бичмэл Үндсэн хуулийн эх баригч нар болох Жеймс Медисон, Жон Адамс нар ч Англид Жон Стюарт, Милл, Токи Велли нар олонхын дарангуйлал Вестмистерийн загвар энэ олонхыг дагадаг ийм тогтолцоо мажоритар тогтолцоогоор үүсчхэж болзошгүй учраас, хэт олонхын тогтолцоо үүсэж болзошгүй учраас энэ Үндсэн хуулийн хяналтын нэг чухал механизм нь цөөнх, парламент дахь цөөнх байна гэж үздэг. Тэгтэл өнөөдрийн энэ сонгуулийн мажоритар тогтолцоогоор чинь хэт олонхын тогтолцоо бүрдээд энэ хяналт тэмцэл Үндсэн хуулийн хяналт тэмцэл алдагдаад байгаа учраас өнөөдрийн энэ холимог тогтолцоо, хосолмол тогтолцоог холимог биш юм л даа. Холимог гэдэг өөр. Энэ олонхыг төлөөлөх буюу хувь тэнцүүлэх энэ зарчим аль аль нь сайнтай, муутай эерэг, сөрөг талыг нь тэнцүүлээд энэ зарчмыг нэвтрүүлбэ гэж байгаа энэ зарчим бол зүйтэй гэж үзэж байгаа. Энэ бол дутуугаа л гүйцээх гэж байгаа хэрэг.

Ер нь энэ цөөнхийн хяналтыг сайжруулахад 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр улс төрийн намуудыг төлөвшүүлэх шаардлага гэж байгаа. Бүх юмны язгуур нь Ардчиллын гол институц болсон улс төрийн намууд маань төлөвшихгүй. Энэ авлига, хээл хахууль алдаа онооны чинь ер нь дийлэнх үндэс суурь язгуур нь улс төрийн намуудтай холбогдоод байна. Нэн ялангуяа парламентад суудалтай нам гэж. Ийм учраас Үндсэн хууль нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улс төрийн намын тухай хуулиа цэгцэлж шинэчлээд, нэр дэвшүүлдэг институц чинь хүний нөөцөө бэлтгэдэг, улс төрөө бэлтгэдэг энэ институцээ эрүүлжүүлэх, санхүүжилтийг нь ил тод, нээлттэй болгох энэ механизм нь хийж байж энэ систем төгс төгөлдөр сайн ажиллана. Мэдээж төгс төгөлдөр Үндсэн хууль дэлхий дээр байхгүй. Төгсөөс төгс юм гэж байхгүй. Яг адилхан Үндсэн хууль ч гэж дэлхий дээр байхгүй. Ер нь дэлхийн ихэнх улсууд дээр пропорциональ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

тогтолцоотой 100 хувь үндсэн хуульчилчихсан улсууд байна. Австри энэ тэрээс авхуулаад. Холимог тогтолцоотой Унгар, Япон, Солонгос гэх мэтчилэн Азийн улсууд ч байна. Ардчилууд ч байна. Дан мажоритар тогтолцоотой Вьетнам энэ тэр гэсэн улсууд ч байна. Тийм учраас энэ тогтолцооныхоо юмыг засахаар ийм өргөн уудам нутаг, газар дэвсгэртэй улсууд, улс үндэстний аюулгүй байдлын асуудал байгаа юм. Энэ тооны асуудал бол. Хүн, амаа дагаж сонгоно гээд байдаг, тэгвэл хүн, амаа дагах юм бол улс орны яг тэр хүн амынхаа тоог дагаад л Улаанбаатараас сонгогдсон гишүүд давамгайлаад л Улаанбаатар дээр хөрөнгө оруулалт нэмэгдээд л, Улаанбаатар дээр төсөв хуваарилагдаад л, Улаанбаатар тэрнийхээ хүрээнээс дагаж шилжилт хөдөлгөөн хийгдээд л, Улаанбаатар улс болно. Хөдөө орон нутаг, байгалийн баялаг, газар нутаг чинь эзгүйднэ. Улсын үндэс газар юм байгаа биз дээ. Ийм учраас энэ тооны ард бол үндэсний аюулгүй байдлын асуудал байгаа гэдгийг бид ойлгох ёстой.

Ийм учраас хөдөө орон нутгаа хөгжүүлэх таны тэр хэлээд байгаа бас орон нутаг ямар болчихсон байлаа, сум аймаг ямар болчихсон байлаа. Батсуурь гишүүний хэлээд байгаа энэ бүх асуудлууд бас үүгээр хангахын тулд нутаг дэвсгэрийн төлөөллийг хэвээр хадгалъя гэсэн зарчмыг, бас энэ мэргэжил холбоод, улс төрийн намуудын төлөөллийг хангая гэсэн энэ зарчмуудыг тэнцүү тэнцвэртэй хангах зарчмыг бол зөв гэж үзэж байгаа юм. Ийм учраас авлигаас ангид, үндэсний аюулгүй байдлын энэ зарчим, эрэлт хэрэгцээндээ нийцүүлсэн, өнөөгийн цаг үе, гадаад геополитикийн нөхцөл байдалтайгаа нийцүүлж бид бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өмнө нь ярьж байснаа ахиж дэвшүүлж хийх шаардлагатай байна гэсэн ийм агуулгаар энийг Засгийн газраас өргөн барьж байна гэж үзэж байна.

Ийм учраас 2019 оны Үндсэн хуулиар тэр суурь зарчмыг хөндөөд байгаа юм байхгүй. Давхар дээлийн асуудал яагаад хөндөгдсөн бэ гэхээр гишүүдийн тооны санал уначихсан учраас тоо нэмэгдэх юм бол давхар дээл юу яах вэ, эрх мэдлийн уусал Fusion of power гэж байгаа. Энэ бол гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдэл бол харилцан уусаж байж болно. Яагаад гэвэл сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн тулд ард түмний хүсэл эрмэлзлийг тэдэнд амласан амлалтаа хэрэгжүүлэхийн тулд энэ эрх мэдлүүд харилцан уусах ёстой. Гагцхүү нөгөө харилцан хяналт, тэнцэл нь алдагдаад тоо цөөн байгаа үед 18, 20 Засгийн газрын гишүүн Их Хурал дээрээ давамгайлах ёстой нөгөө тооны онол, математикийн онолоор чинь давамгайлах тийм тооны хүчин зүйл үйлчлээд байгаа учраас, нэг гишүүний саналын хувь нэг бүхлээс дээш байхаар тэр дарга ангилалд багтаад байгаа учраас энэ ард түмнийг төлөөлөх сууриа бат суурьтай болгох шаардлагатай байна шүү дээ. Бат суурьтай болж байж энэ чинь жоохон хөгжил цэцэглэлт, дэвшил бий болно. Тийм ээ. Тийм учраас энэ Ардчиллын бат суурийг бий болгохын тулд бид бас ард түмнийхээ төлөөлөх чадварыг хангах шаардлагатай гэдгийг бол бас бид хаа хаанаа ойлгоод л энэ саналыг бүх улс төрийн намууд дэмжээд, нэн ялангуяа энэ бол 2019 оны Ардчилсан намын бүлэг, Ардчилсан намын саналаар энэ төсөл өөрчлөлт хийгдэж байна гэсэн. Ардчиллыг бичүүлэхийн төлөө л хийж байна гэж бид ойлгож байгаа шүү дээ. Тийм учраас энэ дээрээ бол бас улс төр хийж болно. Хөшигний ард нэг юм яриад, олон түмэн телевизийн камерын маань өөр ярьдаг байж болохгүй гэдгийг л бүгдээрээ энэ улс орны эрх ашгаа дээдлээд ардчилал, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө бүх зарчмаа дээдлээд хийх ёстой. Хүний эрх, эрх чөлөөний асуудал бол бас авлигатай тэмцэх энэ тэмцэлд нийгмийн өнөөдрийн хэрэгцээ шаардлага болчихоод байгаа учраас дандаа энэ trade of balance тэнцвэрийг нь бид нар олж хангах ёстой. Авлигатай тэмцэх ажил

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

чинь бас хүний эрхийг авлига чинь хүний эрхийг хамгийн их хөсөрдүүлж байгаа зүйл болоод байна. Ийм учраас энэ бүх тэнцвэр дээрээ бид нар бас энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө их ажил хэрэгчээр, үр дүнтэй хэлэлцэх шаардлагын үүднээс зарим нэг ийм тодруулга түүхийг хэлэх нь зүйтэй байх.

1914 оны Цэвээн, Жамсрайгийн Улсын эрх ном ч гэсэн газар нутаг ба хүн амыг төлөөлж доод хурлыг байгуулах, заримыг нь зарлигаар сонгох. Энэ яг парламентын ардчиллын зарчмыг тунхагласан ийм улсын эрх гэж ном тухай бичигдэж байсан. 2022 оны Ардын төр Засгийн газрын анхны Үндсэн хууль боловсруулах зарчим дээр ч гэсэн яг ингэж явж байсан бас түүхэн уламжлал байгаа гэдгийг би бас энд дурдахыг хүсэж байна. Тийм учраас энийгээ ажил хэрэгчээр бүгдээрээ хэлэлцээд, ард түмнийхээ л эрх ашигт нийцүүлээд, ард түмнийг төлөөлөх чадварыг нь л бий болгосон, яг ард түмнийхээ төлөө дуугарч, ажиллаж чаддаг парламент бий болгох энэ өөрчлөлт, шинэчлэлтийг бол бас хэрэгжүүлэх энэ түүхэн цаг үеийг бид үр бүтээлтэй ашиглах ёстой гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Н.Энхболд: Доржханд гишүүн үгээ хэлье.

Т.Доржханд: Баярлалаа. Би 2 минутад багтаагаад товчхон үг хэлье. Нэг дүгээрт энэ нэг тооны асуудал бол ярьж байгаа. Тэгээд гишүүд бол янз янзын байр суурьтай байх шиг байна. Тэрийг нь бол хүндэтгэлгүй л яах вэ. Гэхдээ яагаад 76 юм бэ гэдэг тэр үндэслэлүүдээ сайн гаргаж ирээрэй. Аль эсвэл яагаад 108 ч гэдэг юм уу. Тэгээд бүгдээрээ нөгөө судалгаан дээр үндэслэж ярьдаг байхгүй бол өмнөх алдаагаа давтчих вий гэдэг нэг болгоомжлол байгаа юм шүү. Тийм болохлоор одоо харилцан судалгаатайгаа, тэгээд үндэслэл нь юу юм бэ, яагаад энэ улсад хэрэгтэй юм бэ гэдэг зүйлээ яримаар байгаа юм. Би үг аваад хэлэх гээд байгаа өнцөг нь юу вэ гэхээр нөгөө эдийн

засгийн асуудал байгаа юм. Тэгээд яагаад 50 хувь юм бэ гэдгийг л дахиад нэг хэлчихмээр байгаа юм. Түрүүн манай Нямбаатар сайд бас хэлээд байх шиг байна лээ. Бүр тодорхой тоог нь хэлье. Сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол Улсын эдийн засаг 14 дахин өссөн байдаг юм шүү. 14 дахин. 14 дахин өсчхөөд байхад Монгол Улсын төсөв төрийн зардал 55 дахин өссөн, одоо өсөөд яваад байгаа шүү. Хамгийн хэцүү тоо нь үр дагавар нь Монгол Улсын өр шүү. Монгол Улс өр 70 дахин өсчхөөд байгаа. Жил болгон өсөөд яваад байгаа шүү. Яагаад гэвэл төсөв жил болгон алдагдалтай. Яагаад вэ гэхээр тогтолцооны асуудал байгаа юм. Энэ нөгөө тойргоо санхүүжүүлдэг байх уу, хөгжлийг санхүүжүүлдэг байх уу, цахилгаан станц барих уу, аль эсвэл нэг барилга барих уу гэдэг ийм л сонголт байгаа болохоор бид нар өрнийхөө асуудлыг шийдье гэх юм бол энэ доор хаяж 50 хувь гэдэг нь маш учиртай шүү. Үндэслэлтэй юм. Энэ дээрээ бас үндэслэлүүдээ, судалгаагаа гаргаж ирж байгаад сайхан мэтгэлцмээр байгаа юм. Иргэд дээ бас ойлгуулмаар байгаа юм.

Тэгээд 1 зүйлийг хэлье. Нөгөө Батсуурь гишүүн маань бас ингээд хэлээд байх шиг байна л даа. Энэ Доржханд ингээд дарангуйлагч болчих вий гээд. Битгий санаа зовоорой. Тэгээд бид бол өнөөдөр цүнх баригч гэдэг ойлголт манай намд байдаггүй. Харин бусдынхаа цүнхийг бол бариад явах боломжтой байдаг. Цаашаа бол маш олон бодлого боловсруулах чадвартай мөнгөөр биш, бодлогын асуудлаар мэтгэлцэх чадвартай олон залуучуудыг оруулж ирнэ. Парламентад оруулж ирнэ. Ингэж байж парламентын нэр хүнд дархлааг бол өсгөх ажилд ХҮН намын зүгээс бид хувь нэмэр оруулаад явна гэдгээ албан ёсоор бас мэдэгдье. Баярлалаа.

Н.Энхболд: Гишүүд хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулж үг хэлж дууслаа. Одоо санал хураана. Гишүүдээ дуудаарай. Түрүүн ирцэд орсон байсан гишүүн. Амарсайхан, Бямбацогт,

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

Занданишатар, Ганболд гишүүд танхимд ирье. Санал хураах гэж байна. Өөр хэн байна. Хэн байлаа, Сүхбаатар гишүүн. Байна уу. Сараагийн ард орчхоод харагдахгүй байсан байна шүү.

Чуулган дээр хэлчих. Пүрэвдорж гишүүн бас танхимдаа ирье. Санал хураахад бэлдээрэй. Энэ хооронд би нэг зүйлүүдийг танилцуулъя. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх дэгтэй холбогдуулаад төсөл өргөн барьснаас хойш 1 сарын дотор хэлэлцэж эхлэх ёстой. Бид нар 2 хоногийн дараа хэлэлцээд эхэлж байна. Нийтдээ 3 удаагийн хэлэлцүүлгээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ярина. Хэлэлцүүлэг хоорондын хугацаанд олон нийтийн хэлэлцүүлэг явуулна. Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлаас тогтоол гараад, олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулах, тэдний байр суурийг тодорхойлох, санал, дүгнэлтийг нь сонсох ийм хэлэлцүүлгүүдийг 2 удаа явуулна. Хэлэлцүүлэг нэгэнт эхэлснээс хойш бусад асуудлуудыг Улсын Их Хурлаар хэлэлцэхгүй тасралтгүй үргэлжлүүлж явуулж байгаад, 3 хэлэлцүүлгээрээ баталж дуусгах ёстой ийм дэгтэй байгаа шүү гэдгийг бас гишүүддээ, манай хуралдааны явцыг ажиглаж байгаа иргэд, сонгогчдод бас хэлчихье. Хуулийн заалтууд нь ийм байгаа юм.

Одоо ингээд санал хураалтаа явуулна. Гишүүд бүртгэлд орсон байсан гишүүд Занданишатар даргыг дуудаарай. Пүрэвдорж гишүүнийг дуудаарай. Амарсайхан сайд яачхав. Бямбацогт сайд яачхав. Сугалчихсан юм уу. Санал хураалт явуулна. Дэгээ сануулъя. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй саналаар асуудлыг шийднэ. Одоо ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 15 гишүүн санал хураалтад оролцож, 12 гишүүн дэмжиж,

Байнгын хорооны гишүүдийн хуралдаанд оролцсон гишүүдийн 80 хувь нь Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж шийдлээ.

Санал, дүгнэлтээ би хуралдаанд танилцуулчихъя.

11.58 цаг

Дараагийн асуудалдаа орёё. Дахиад нэг асуудал байгаа шүү. Засгийн газрын гишүүд ээ, байж байгаарай.

Одоо Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Энэ хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газар 2023 оны 5 сарын 3-ны өдөр өргөн мэдүүлсэн. Төсөл санаалагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг өргөн мэдүүлсэнтэй холбогдуулж, дагаж мөрдөх журмын тухай хуулийг давхар, хамтад нь өргөн мэдүүлж байгаа. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн гол агуулга бол Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдмагц хэрхэн шилжилт хийх харилцааг зохицуулсан байгаа. Ийм учраас уг хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгнө үү.

Н.Энхболд: Баярлалаа. Асуулттай гишүүн байна уу. Алга байна.

Уг хэлэх гишүүн байна уу. Байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хууль оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

15 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Мөнхцэцэг гишүүн чуулганд танилцуулъя.

12.01 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудал, энэ удаагийн хэлэлцэх асуудал дууслаа.

Чуулганаар өөрчлөлтийг хэлэлцэх асуудлыг хэлэлцсэний дараа Байнгын хороо дахиж хуралдаж, Их Хурлын тогтоол ярина. Энэ нь ажлын хэсэг байгуулах, хугацааны тухай асуудлууд байгаа.

Гишүүддээ баярлалаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ